MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,159.762... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.08.23. Лхагва. №139 (4753) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +13
Шөнө +7

УЛС ТӨР

МАХНЫ ҮЙЛДВЭР БАРИХ ЧИГЛЭЛЭЭР АРАБ УЛСТАЙ ХАМТАРНА

II нүүрт

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

ТЕХНИК НЬ ЭЛЭГДСЭН Ч, ТҮЛШ АЛДААГҮЙ БАГАНУУРЫНХАН

VI-VII нүүрт

Дугаарын 60 мөр

## Оторлохдоо халдварт өвчин тараах нь онцгүй

Г.ГАНЧИМЭГ

Манай малчид өнгөрсөн өвөл 61.5 сая толгой мал тоолуулж, хавар нь 21.9 сая төл хүлээн авчээ. Одоо малын тоо толгой 80 саяыг даваад байна. Монголчууд жилд 10 гаруй сая мал нядалж, махныхаа хэрэгцээг хангадаг. Харин энэ жил ихэнх нутгаар ган гачигтай тааруухан зуншлаа. Тодруулбал, нийт нутгийн 43 хувь нь гандуу, 34 хувь нь гантай зусчээ. Тиймээс өвөлжилт хүндэрч болзошгүй гэж үзээд энэ жил ойролцоогоор 14 сая мал гаргахаар төлөвлөж буй аж. Ингээд улсын хэмжээнд 66 сая толгой мал өвөлжинө гэдэг статистикийг салбарын яамнаас нь гаргажээ. Хамгийн асуудалтай нь нийт нутгийн 77 хувь нь гантай болон гандуу зуссан учраас отор нүүдэл хийх нь гарцаагүй.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## СЭТГЭЛГҮЙ САЙД НАР Л ЗАСГИЙН ГАЗРЫН НЭР ХҮНДИЙГ УНАГАЖ БАЙНА



Н.ПУНЦАГ

УИХ-ын 2016 оны сонгуульд МАН үнэмлэхүй ялалт байгуулсан. Эл ялалтын дараа хамгийн түрүүнд “Мэргэжлийн” гэх тодотголтой Засгийн газар байгуулах болсон тухайгаа сүртэй зарласан билээ. Харамсалтай нь Засгийн газар байгуулагдаж, сайдууд томилогдохтой зэрэгцээд тодотголоосоо хол зөрж, иргэдийг бухимдуулсан. Мэдээж томилогдсон сайдуудын ихэнх нь мэргэжлийн бус. Гэхдээ сайд нар бүгдээрээ мэргэжлийн бус биш, сайн ажиллаад, салбараа мэдээд, мэдрээд явж байгаа сайдууд чамгүй олон бий. Гэвч үнэнийг хэлэхэд сайнаасаа саар нь илүү гарчихаад байгаа юм. Тиймдээ ч Засгийн газрыг огцруулах асуудал үе үе хөндөгдсөн. Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа бүр ч эрчээ авчихлаа. Огцруулах шалтаг нь ч олон болж эхэллээ. Одоо эрх баригч нам дотроо хагаралдаж, хоёр хуваагдчихаад байна.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ



## Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга орон тооны бус зөвлөхүүдээ томилов

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга захирамж гаргаж, орон тооны бус зөвлөхүүдээ томилов. Үүнд, Ч.Чулуунцэцэгийг Багшийн хөгжлийн асуудал хариуцсан, О.Амгаланбаатарыг Гааль, татварын асуудал хариуцсан, Ч.Ганбатыг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан, С.Пүрэвсүрэнг Хүмүүнлэгийн асуудал хариуцсан, Ц.Ууганбаярыг Гэр хорооллын барилгажилтын асуудал хариуцсан, Ш.Батцэцэгийг Ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан, Л.Эрдэнэчимэгийг Эм, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын асуудал хариуцсан, Д.Жаргалсайханыг Үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэх асуудал хариуцсан зөвлөхөөр томилжээ. Мөн С.Чулууныг Монгол судлалын асуудал хариуцсан, Ц.Чинбатыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан, Ц.Сосорбарамыг Усны асуудал хариуцсан, Б.Баатарыг Кино урлагийн асуудал хариуцсан, Н.Лхагвадоржийг Оюутны хөгжлийн асуудал хариуцсан, С.Дэмчигийг Залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан, Н.Оргилыг Кино урлагийн асуудал хариуцсан, Л.Баян-Алтайг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөхөөр тус тус томилсон байна. Харин Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөхөөс Д.Сосорбарам, Ц.Бямбажав, Х.Цагаанбаатар, Ч.Отгочулуу, Б.Бямбасайхан нарыг чөлөөлжээ.




**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2438.00 | 2452.00 | ФУНТ | 3108.00 | 3186.00 |
| ЕВРО | 2852.00 | 2913.00 | РУБЛЬ | 40.40 | 42.40 |
| ИЕН | 22.16 | 22.59 | ЮАНЬ | 364.50 | 367.90 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2435.00 | 2452.00 | ФУНТ | 3110.00 | 3190.00 |
| ЕВРО | 2857.00 | 2921.00 | РУБЛЬ | 40.55 | 42.80 |
| ИЕН | 22.06 | 22.69 | ЮАНЬ | 364.00 | 367.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## О.Баасанхүү ээлжит бус чуулган хуралдуулах хүсэлтийг Ерөнхийлөгчид хүргүүлэв

УИХ-ын гишүүн О.Баасанхүү "УИХ-ын ээлжит бус чуулганыг есдүгээр сарын эхний долоо хоногт багтаан зарлан хуралдуулах" зарлиг гаргуулах хүсэлтийг өчигдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад хүргүүлжээ. Тэрбээр дөрвөн үндэслэлээр ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах ёстой гэж үзсэн байна. Тодруулбал, улсаас хүүхэд бүрт олгодог 20 мянган төгрөгийн санхүүжилтийн асуудлыг улсын төсөвт тусгуулж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулах, Монгол Улс 2018 оны нэгдүгээр сарын 05-ны өдөр "Чингис" бондын эргэн төлөлт болох 500 сая доллар, мөн оны тавдугаар сард БНХАУ-аас зээлсэн нэг тэрбум доллартай тэнцэх юанийн зээлийн хүү болох 160.0 сая долларыг төлөхөөр байгаа тул бэлтгэл ажлын талаар хэлэлцэж шаардлагатай арга хэмжээг авах. Өвөлжилт хүндрэх төлөвтэй байгаа тул Засгийн газраас өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангасан эсэхэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд УИХ-аас холбогдох шийдвэрүүдийг нэн даруй гаргуулах, төсөвт тодотгол хийж, багш нарын зохих нэмэлт цалин, урамшууллыг төсөвт тусгуулах гэсэн үндэслэлийг нэрлэсэн байна. УИХ-ын тухай хуулийн 16.2 дахь заалтад зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргасан тохиолдолд УИХ-ын ээлжит бус чуулган хуралдах хууль эрхзүйн боломжтой аж.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# МАХНЫ ҮЙЛДВЭР БАРИХ ЧИГЛЭЛЭЭР АРАБ УЛСТАЙ ХАМТАРНА






...Саудын Арабын хунтайж Абдулла Бин Абдулрахман Бин Абдулазиз Аль Сауд "Манай улсын хувьд махны хэрэглээ өндөр улс. Хамтарсан махны үйлдвэр байгуулах талаар судалж хамтарсан ажлын хэсэг байгуулах саналтай байна" гэдгийг хурлын үеэр онцоллоо...

Э.ТУУЛ

ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн Саудын Арабын хунтайж Абдулла Бин Абдулрахман Бин Абдулазиз Аль Сауд тэргүүтэй төлөөлөгчдийг өчигдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн хунтайж Абдулла Бин Абдулрахман Бин Абдулазиз Аль Саудыг хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлээд Хүнс, хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн зорилтын талаар товч мэдээлэл өгөв. Тодруулбал, "Монгол Улсын Засгийн газраас хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт "Эрүүл хүнс- Эрүүл монгол хүн" уриан дор "Мах сүүний анхдугаар аян", "Үйлдвэржилт 21:100", "Атрын III аян"-ыг үргэлжлүүлэх зэрэг томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. "Мах, сүүний анхдугаар аян"-ыг хэрэгжүүлж эхэлснээс хойш олон ажил хийж байгаагийн нэг нь махны экспортыг нэмэгдүүлэх юм. Монгол Улс Саудын Араб улстай хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах өргөн боломж байгаа. Манай улс мал, мах экпортлох асар их нөөц бололцоотой орон. Монгол Улс жилд дунджаар 150.4 гаруй мянган тонн мах экспортлох боломжтой гэсэн тооцоолол бий. Манай улсын нийт малын тоо өнгөрсөн оны байдлаар 61.5 сая толгойд хүрсэн. Өнгөрсөн онд 9.2 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн ОХУ, БНХАУ руу экспортолсон. Хөрш орнуудын зах зээлийн эрэлт нь гол төлөв бод малын мах байдаг. Харин манай улсын нийт малын 85 орчим хувийг бог мал эзэлдэг. Тиймээс хонь, ямааны мах гуравдагч орнууд руу экспортлох нөөц бололцоо байгаа учир бог малын махны экспортын чиглэлээр хамтран ажиллах, хамтарсан махны үйлдвэр байгуулах сонирхолтой байна" хэмээн онцлон тэмдэглэв. Саудын Арабын хунтайж Абдулла Бин Абдулрахман Бин Абдулазиз Аль Сауд "Манай улсын хувьд махны хэрэглээ өндөр улс. Хамтарсан махны үйлдвэр байгуулах талаар судалж хамтарсан ажлын хэсэг байгуулах саналтай байна" гэдгийг хурлын үеэр онцоллоо. Хуралдааны төгсгөлд Саудын Арабын хунтайж Абдулла Бин Абдулрахман Бин Абдулазиз Аль Сауд ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэнг өөрийн улсад албан ёсны айлчлал хийхийг урьж, хүлээн авч уулзсанд талархал илэрхийллээ.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
90873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Гаргасан шийдвэрээ эргэн харахыг Хотын удирдлагуудад үүрэгдэв

Энэ сарын 15-наас эхлэн нийслэлийн төв зам буюу баруун дөрвөн замаас зүүн дөрвөн зам хүртэл зүүн гар тийш эргэхийг хориглосонд иргэд ихээхэн бухимдаж байгаа. Гэвч хотын удирдлагуудын зүгээс түгжрэл буурсан үзүүлэлттэй байгаа хэмээн мэдээлээд байгаа юм. Тэгвэл Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат өчигдөр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын удирдлагуудыг хүлээн авч уулзлаа. Энэ үеэрээ Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах чиглэлээр, ялангуяа замын зарим хэсэгт зүүн эргэх хөдөлгөөнийг хязгаарласан арга хэмжээний үр дүнгийн талаар мэдээлэл сонсчээ. Замын цагдаагийн удирдлагуудын танилцуулснаар хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан жил бүрийн наймдугаар сарын 15-25 бол замын хөдөлгөөний хамгийн их ачаалалтай үе юм байна.

Энэ үеэр орон нутгаас хот руу чиглэсэн зорчигч урсгал мөн хамгийн их байдаг аж. Түүнчлэн ачааллын яг энэ үеэр Энхтайваны өргөн чөлөөний замын зарим хэсэгт зүүн эргэх хөдөлгөөнийг хязгаарласан нь олон жилийн судалгаатай, тооцоотой бөгөөд үр дүнгээ өгөх арга хэмжээ болохыг тэд онцоллоо. Зүүн эргэх хөдөлгөөнийг хязгаарласан талаар иргэдийн дэмжлэг, гомдол адил тэнцүү буюу 50:50 хувьтай байгаа, цаашид туслах чиглэлийн зарим замыг өргөтгөх чиглэлээр зарим арга хэмжээг авч эхэлснээ нийслэлийн Засаг дарга С.Батболд танилцууллаа. Харин Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат хүний амьдралын хэмнэлийг өөрчилсөн шийдвэр судалгаатай, бүх талаар иргэндээ ашигтай байх ёстойг анхааруулав. Мөн энэ шийдвэрээ улам боловсронгуй болгох чиглэлээр ямар арга хэмжээ авах, ер нь зүүн эргэх хөдөлгөөнийг хориглохыг хотын иргэдээс асуух, судалгааны дүнг үндэслэж шийдвэрээ гаргах талаар долоо хоногийн хугацаатай үүрэг өгч эргэж танилцуулахыг үүрэг болголоо. Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 876 мянга гаруй автомашин замын хөдөлгөөнд оролцдогоос 505 мянга орчим нь нийслэлд байдаг юм байна. Дашрамд дурьдахад, зүүн эргэхийг хориглосон зам дээр оргил цагт хөдөлгөөний нягтрал их болж, гол замын хөдөлгөөн уулзваруудын хооронд түгжирч, босоо замд нөлөөлдөг гэдгийг албаны хүмүүс хэлсэн. Гэвч энэхүү шийдвэрийг иргэд эсэргүүцэж, дэмжихгүй байгаагаа илэрхийлсээр байгаа билээ.

## Ерөнхийлөгч Д.Пүрэвдавааг зөвлөхөөрөө томиллоо

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга захирамж гаргаж, Даваахүүгийн Пүрэвдавааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Байгаль орчин, хот, хөдөөгийн хөгжлийн бодлого, агаарын бохирдлын асуудал хариуцсан зөвлөхөөр томиллоо. Д.Пүрэвдаваа нь Монгол Бизнес дээд сургууль, Удирдлагын академийг тус тус төгссөн. "Интернэт хаус" ХХК-д менежер, "Юу Би Нэт" ХХК-д гүйцэтгэх захирал, "Петровис" ХХК-д менежер, "Цэнан" ХХК-д гүйцэтгэх захирал, нийслэлийн Засаг даргын Үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан орлогч, нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргаар тус тус ажиллаж байсан билээ.

## Ерөнхий сайд мэндчилгээ дэвшүүллээ

Хилийн чанад дахь монгол оюутан залуучуудын анхдугаар чуулга уулзалт Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор өчигдөр Төрийн ордонд боллоо. Чуулга уулзалтад оролцогчдод Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат мэндчилгээ дэвшүүлсэн бөгөөд мэндчилгээг Монгол Улсын Ерөнхий сайдын гадаад бодлогын зөвлөх Н.Чимгүүндарь уншиж сонордууллаа. Мэндчилгээнд "Дэлхийн өнцөг булан бүрт суралцаж байгаа болон эх орондоо суралцаж буй оюутан залуус, хилийн чанадад боловсрол эзэмшсэн салбар салбартаа тэргүүлэгч үе үеийн төгсөгчид өө! Эх орны маань гэрэлт ирээдүй, их бүтээн байгуулалтын эзэд болох оюутан, залуучууд та бүхэн эвлэлдэн нэгдэж, хилийн чанад дахь монгол оюутан залуусын анхдугаар нэгдсэн чуулга уулзалтыг зохион байгуулж байгаад талархал илэрхийлье. Та бүхний Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах цаашдын их үйлсэд амжилт хүсэн мэндчилж байна. Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулж буй энэ удаагийн чуулганд дэлхийн өнцөг булан бүрээс хүрэлцэн ирсэн Монгол залуус Та бүхэн эх орныхоо мэдлэгт суурилсан тогтвортой хөгжлийн төлөө өөрсдийн санал, санаачилгыг дэвшүүлэн чуулж буй явдлыг Монгол Улсын Засгийн газраас өндрөөр үнэлж байна. Хилийн чанадад оршин сууж буй иргэдээ нэгдсэн бүртгэлд хамруулах, дэлхийн топ сургуулиудад Монгол Улсад нэн шаардлагатай мэргэжилтнүүдийг бэлтгэх, хилийн чанадад боловсрол эзэмшиж байгаа болон ажил эрхэлж байгаа залуусыг эх орондоо түр хугацаанд буюу бүрмөсөн суурьшиж ажиллах таатай нөхцөлийг хангахад Монгол Улсын Засгийн газар өндөр ач холбогдол өгч ажиллаж байна. Энэ хүрээнд "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", "Зөгийн үүр" "Дэлхийн монголчууд" хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Манай улс уул уурхай, аж үйлдвэр, дэд бүтэц, хөдөө аж ахуйн салбарт томоохон төслүүд хэрэгжүүлж эхлээд олон жил өнгөрсөн ч гадны зөвлөх үйлчилгээ авсаар байна. Цаашдаа гадаадын зөвлөх, мэргэжилтнийг өндөр үнээр авалгүй, хилийн чанадад нарийн мэргэжил эзэмшсэн иргэнээ ажиллуулах нь зүйтэй юм. Монгол Улсын хөгжлийн бодлого нь "Даян дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр", "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"-тай уялдаж, мэдлэгт суурилсан нийгмийг цогцлоох олон улсад өрсөлдөх ур чадвар бүхий монгол хүнийг төлөвшүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн чадварлаг хүний нөөцийн системийг хөгжүүлэх, боловсронгуй болгоход чиглэж байна. Олон улсад өрсөлдөх чадвар бүхий шинэ цагийн шилдэг мэргэжилтэн олноор бэлтгэгдэж, Монгол Улсаа хөгжийн шинэ шатанд гаргахыг хүсэн ерөөе" гэжээ.

ШАР МЭДЭЭ



## Зуд болох сургаар зугтааж одов уу

Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх намынхандаа омгорхож, ажил албан тушаалаа хүлээлгэн өгөх өргөдлөө өгөөд амжсан. Түүний энэ үйлдлийг сайшаан магтах нэгэн байхад өөлж, гоочлох хүн ч бас байна. Учир нь энэ жилийн өвөл хахир хатуу болох, цаашлаад зуд болж магадгүй талаар хүмүүс ярьж буй. Гэтэл өвөлжилтийн бэлтгэл хангах, хадлан тэжээл базаах гээд хүнд өвлийг давах нөр их ажилтай, зуд турхнаас урьдчилан сэргийлэх шаардлагатай байгаа яг эгзэгтэй үеэр У.Хүрэлсүх ажлаа хаяад зугтааж байгаа нь олны таашаалд лав нийцсэнгүй. Цаашлаад энэ бол наад захын ёс зүйтэй улстөрчөөс гарах үйлдэл лав биш хэмээн ярилцаж байх юм. Угтаа бол У.Хүрэлсүхийг улс, эх орноо боддог байсан бол ийм үйлдэл хийхгүй, харин ч амиа бодож, арьсаа хамгаалаад зугтлаа гэж байгаа нь үнэний ортой ч юм шиг.

# ҮЗЭЛ БОДОЛ

# СЭТГЭЛГҮЙ САЙД НАР Л ЗАСГИЙН ГАЗРЫН НЭР ХҮНДИЙГ УНАГАЖ БАЙНА

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Дээр, дооргүй л бужигнаж байна. Тэр ч битгий хэл Шадар сайд нь огцрох өргөдлөө өгчихлөө. УИХ ээлжит бусаар хуралдаж, асуудлыг нь шийдэхгүй гэвэл намрын чуулган эхлэхээр л огцруулах уу, яах вэ гэдгээ шийдэх байх. Дээр нь ойрын үед Засгийн газрыг огцруулах бичгийг өргөн барих асуудал ч яригдах боллоо. Засгийн газрыг огцруулах гэж байгаа тал шударга ёс, хариуцлага нэхэж байгаа хэмээн тайлбарлаж буй. Ерөнхий утгаараа шүү дээ. Харин нөгөө талаас гарын үсэг цуглуулагчид эрх мэдлийн төлөө улайрч эхэлсэн гэж хариу тайлбар хийсээр. Ямар ч байсан Засгийн газар ганхаж эхэллээ. МАН-ын Бага хурал, Их хурал ирэх сард хуралдах учиртай. Тэр хурлаар олон асуудал шийдэгдэх болов уу. Түүнээс өмнө бол хоёр тал ширүүхэн үзэх нь тодорхой байна. Бие биеийнхээ эсрэг янз бүрээр дайрах нь тодорхой боллоо. Дайраад ч эхэллээ. Угтаа Засгийн газар жаахан тогтвортой ажиллавал зүгээр байгаа юм. МАН-ыг ард түмэн эв түнжинтэй байж, Засаг төрөө солихгүй, өөрчлөхгүй, “самрахгүй” гэж сонгосон. Мэргэжлийн Засгийн газар ажлаа эхлээд жил л болж байна. Өнгөрсөн хугацаанд боломжийн хэмжээнд ажиллаж байгаа. Сүүлийн нэг жилд гарсан эдийн засгийн өөрчлөлт, ахиц дэвшлийг харвал огцруулах нь битгий хэл улам ч хүч нэмэн ажиллуулмаар байгаа юм. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг одоогоор тэгж муу ажиллалаа, ингэжалдаахийлээгэжгоочилж, шүүмжлэхээр зүйл алга. Улс орны боломж бололцоо ямар байгаа билээ. Эдийн засгийн чадавхиа аваад үзье. Нөхцөл байдал хэдий ийм ч чадлынхаа хэмжээнд харин ч боломжийн сайн ажиллаж байгаа санагдах юм. Гэтэл сайны хажуугаар саар гэгчээр салбарын сайдууд нь тун тааруу ажиллаж, нэрмээс болоод байна. Тухайлбал, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарыг нэрлэж болно. Өнөөдөр Монголын эрүүл мэндийн салбар ямар байгаа билээ. Хэдэн эмнэлэг нь яаж ажиллаж байгааг хүн бүр л хэлнэ. Улсын эмнэлэгт үхэхээс наагуур очвол л эмч нь үздэг шахам болчихсон. Дугаар аваад үзүүлнэ гэвэл хол хэвтэнэ. Эмчид үзүүлье гээд дугаар авах гэхээр долоо, 14 хоногийн дараа ир гэдэг. Үнэхээр хүндээр өвчилсөн бол түргэнээ дууд гэнэ. Эх нялхасын эмнэлгийн ойр хавь гэхэд л дүүрэн шалбааг. Хөл хүнд эхчүүд явах зам нь бороо орохоор ус дүүрчихдэг гээд иргэд гомдол мэдүүлж л байна. Гэх мэтээр бичвэл эрүүл мэндийн салбарын асуудал үй түм. А.Цогцэцэг сайд ажлаа авснаас хойш чухам юу хийв. Хөдөө, орон нутагт хэдэн түргэний машины асуудал шийдчихэж чадахгүй Шадар сайдад загнуулж байсныг л санаж байна. Хамгийн сүүлийн үеийн мэдээ харахад, мань хүнд Бээжинд болж байгаа чуулга уулзалтад л оролцож байгаа бололтой юм. Гэтэл өнгөрсөн зун Гэмтлийн эмнэлгийн эмч нар нь хөдөө явж байгаад осол ороод, бөөн юм болсон. Эрхэм сайд шагнаад, эмч нараа амралтад явуулсан гээд байгаа. Гэтэл эмч нарын ар гэрийнхэн нь сонгуулийн сурталчилгаанд дайчилсан гэсэн мэдээлэл өгч байлаа, тэр үедээ. Ийм том асуудал үүсч, тэр хэрээр Засгийн газрын нэр хүнд унаад л өнгөрсөн. Харин сайдтан яав, чуулга уулзалтад оролцсон шиг л явна. Сангийн сайд Б.Чойжилсүрэн Засгийн газрын нэр хүндийг хамгийн их унагаж байгаа хүний нэг гээд хэлчихэд буруудахгүй. Анх ажлаа аваад, Үндэсний телевизээр улс орон сүйрсэн мэтээр ярьснаас нь хойш түүнийг огцруулах санал хүртэл гарсан. Хамтын тэтгэврийн хуулийг буцаах үедээ хийсэн тайлбарыг сонссон намынхан нь хүртэл “Нялх хүүхдээс дор юм ярьж, намын нэр хүнд унагаалаа” хэмээн бухимдаж байсан ч удаа бий. Өнгөрсөн Ерөнхийлөгчийн сонгуулиар хамгийн их жишээ болсон хүн мөн л Б.Чойжилсүрэн сайд. Тост, Тосон бумбын нуруутай, холбоотой асуудал чамгүй л сөхөгдөж байлаа. Энэ талаар сайд асан Ц.Оюунгэрэл зураг хөрөг харуулаад л ярьсан. Цаашид ч энэ асуудал яригдаж таарна. Дээр нэр дурьдсан сайдууд дотроос хамгийн сайн ажиллах нь Г.Мөнхбаяр болов уу гэж харж байлаа. Гэвч өнгөрсөн хугацаанд энэ салбарт олигтой ахиц дэвшил гарсангүй. Шугам хоолойн урсгал засвар энэ тэрийг яриагүй шүү. Байнга хийдэг тэр ажлууд бол явдгаараа л явна. Харин Улаанбаатар хотыг орон сууцжуулах, иргэдээ дулаан тохилог байранд амьдруулах. Цаашлаад орон сууцжуулах замаар агаар, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлд өнөөдрийг хүртэл нэг жилийн хугацаанд дорвитой ажил хийсэнгүй. Мэдээж энэ мэт ажлыг хийхэд ганц салбарын хүч хүрэхгүй нь ойлгомжтой. Гэхдээ салбарын сайд нь сайн ажиллавал бас үр дүн гаргаж бололгүй л яах вэ. Тийм жишээ зөндөө бий. Гэтэл иргэдийг орон сууцанд орох боломжоор хангаж байсан ганц хөтөлбөр нь бараг л зогсчихлоо. Ипотекийн зээл өгч байгаа үгүй нь мэдэгдэхгүй байна. Монголбанкнаас зээлийн эргэн төлөлтөөс орж ирж байгаа хэдэн төгрөгийг буцааж өгч байгаа л гэдэг. Сардаа 25-30 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт гаргасан гэж мэдээлдэг. Тэр мөнгө нь иргэдэд очиж байгаа ч юм уу, үгүй ч юм уу л байна. Ирэх жилээс янз бүрийн орон сууцны хөтөлбөр хэрэгжих юм гэнэ лээ. Өөр олон төлөвлөсөн ажлынхаа талаар эрхэм сайд хэвлэлд ярьсан байна билээ. Гэхдээ иргэдэд төлөвлөлт биш бодит ажил л хэрэгтэй байна. Уул уурхайн сайд Ц.Дашдорж гэдэг хүн ч байгаа байхгүй нь мэдэгдэхгүй юм үнэндээ. Наадмын өмнөхөн “Алт-2” хөтөлбөр хэрэгжих нь гэж дуулдаад сураг алдарсан. Улсын эдийн засаг сул үед алт эдийн засгийн эргэлтэд орж байвал түүн шиг сайн зүйл үгүй. Түүнчлэн Цагаан хадны боомтын асуудлыг нэрлэж болно. Өнөөдөр асуудал тартагтаа тулчихлаа. Нүүрс зөөж байгаа хэдэн жолооч нар нь хонон өнжин дугаарлаж зогсдог ажилтай болсон. Энэ жил урагш нь гаргахаар төлөвлөсөн нүүрснийхээ хэмжээнд хүрэхээргүй болж магадгүй байна гэсэн мэдээлэл ч бий. Харин Засгийн газраас Цагаан хадны боомтын хяналтыг байхгүй болгох шийдвэр гаргасан, саяхан. Гэтэл олон хүн ажилгүй болно гээд л бөөн эсэргүүцэлтэй тулж байх шиг байна. Энэ мэтээр салбар салбарт л олон асуудал байгаа. Түүнийгээ аятайхан шийдчихэж чадаж байгаа сайд тун цөөн байна даа. Энэ бүхэн Засгийн газрыг огцруулах шалтгааны томоохон хэсэг болчихоод байгаа юм. Угтаа зарим сайдын ажлаа олигтой хийхгүй байгаа нь Засгийн газар огцруулах шалтгаан болох ёсгүй. Ерөнхий сайдЖ.Эрдэнэбатынбүрдүүлсэн баг биш, улс төрийн, цаашлаад мөнгөний томилгоо учраас тэд дур дураараа л авирлаж байгаа шүү дээ. Харин Ерөнхий сайд өөрөө багаа бүрдүүлж, сайд нараа томилсон байсан бол түүнээс хариуцлага нэхэх ёстой байлаа. Гэвч өнөөдрийн хувьд тийм биш. Хэрвээ намаа цэвэрлэж, хариуцлага шаардаж байгаа бол хэргийн эзэн, хэнгэргийн дохиуруудаа л “цавчина” биз. Жил ажилласан Засгийн газрыг огцруумлаа гээд МАН гоё харагдана гэдэг нь юу л бол.




> ...Дээр нэр дурьдсан сайдууд дотроос хамгийн сайн ажиллах нь Г.Мөнхбаяр болов уу гэж харж байлаа. Гэвч өнгөрсөн хугацаанд энэ салбарт олигтой ахиц дэвшил гарсангүй. Шугам хоолойн урсгал засвар энэ тэрийг яриагүй шүү. Байнга хийдэг тэр ажлууд бол явдгаараа л явна...

Дугаарын 60 мөр

## Оторлохдоо малынхаа хөлөөр халдварт өвчин тараах нь онцгүй

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Одоогийн байдлаар Дорнод, Сүхбаатар аймагт өвсний гарц сайн байгаа юм. Малчин хүн уулын цаадахыг сонордож, усны тунгалагийг хардаг ухаан чадалтай учраас чихэнд чимэгтэй энэ мэдээг хэдийнэ сонсч мэдэлгүй яах вэ. Урьдчилсан байдлаар ган гачигтай зуссан аймгуудын 21.4 мянган малчин өрх 9.2 сая малаа Сүхбаатар болон Дорнод аймгийн нутагт оторлож өвөлжүүлье гэдэг хүсэлтэй байгаа юм байна.

Гагцхүү өнгөрсөн оны эхээс өнөөдрийг хүртэл 13 аймгийн 80 гаруй суманд шүлхий, мялзан, цэцэг зэрэг мал, амьтны гоц халдварт өвчин гарсан, гарсаар ч байна. Хамгийн сүүлд гэхэд Хэнтий аймагт үхэр хэд хэдээрээ үхжээ. Яг ямар өвчний улмаас ийн үхэж үрэгдсэнийг тодруулахын тулд шинжилгээний дээжийг хот руу явуулаад байгаа ч хариу нь хараахан гараагүй байгаа гэнэ. Юутай ч зүүн гурван аймгаас үхрийн мах хот руу оруулахгүй байгаа аж. Зарим малчин отрын малын хөлөөр мал амьтны гоц халдварт өвчин тарсан байж болзошгүй гэж сэжиглэж буй бол нөгөө хэсэг нь бэлчээр усны доройтлоос болоод малын өвс, тэжээл шимгүйдэж давжаарч байгаа. Улмаар зарим ядарсан мал тэжээлийн дутагдалд ороод турж үхэж байна гэж таамаглаж буй юм билээ. Үүнээс өмнө буюу өнгөрсөн сард ХХААХҮЯ-аас “Отрын мал гоц халдварт өвчин тархсан бүс нутгаас эрүүл газарт очиж мал, амьтны өвчин таравж байж болзошгүй” гэж таамаглаж буйгаа мэдэгдэж байсан юм. Тиймээс сум, орон нутгийн төвшиндөө энэ ажилд хариуцлагатай хандаж, бүх малаа үзлэг шинжилгээнд бүрэн хамруулахыг сануулж байв. Үзлэг шинжилгээнд хамрагдсан малыг бичиг баримтжуулж, бусад аймгийн нутагт оторлох болбол бүрдүүлсэн бичиг баримтаа тухайн аймаг, сумын Засаг дарга нарт шалгуулах, Засаг дарга нар ч отрын малын бичиг баримтыг заавал үзэх ёстой аж. Харин энэхүү үүрэг даалгаврыг бодит амьдрал дээр хэрхэн яаж хэрэгжүүлж буйг байсхийгээд л гарсаар байгаа мал, амьтны гоц халдварт өвчин, түүний тархалт, давтамж илчлээд өгнө. Энэ нь цаашилбал Монгол Улсын эдийн засагт ч тодорхой хэмжээгээр хор хохирол учруулж буй юм. Манай улс импортлогч биш үйлдвэрлэгч орон болох хүсэл мөрөөдлийг тээж байна. Ухдаг биш ургуулдаг, дуусч дундардаг биш өсч үрждэг баялгийг бүтээхийн төлөө буюу ногоон эдийн засгийн үзэл баримтлалыг ч сүүлийн жилүүдэд илт дэмжиж байгаа. Гэхдээ бидэнд бас нэг алдаа байна. Тухайлбал, бэлчээрийн мал үржил шимтэй газрын хөрсөнд ургасан өвс ургамлыг сорчилж идэн, усны тунгалагийг уудаг учраас монгол малын мах дэлхийд байхгүй чанартай хэмээн сурталчилдаг. Ингээд хамтарч ажиллая, энэ тэр гээд гадаад, дотоодын түншүүдтэйгээ ярьж байгаад эргээд хартал энд ч шүлхий, тэнд ч цэцэг гэх нь даанч харамсалтай. Соёлт хүн төрөлхтөнтэй мөр зэрэгцэн ажиллаж, амьдаръя гэвэл дэлхийн стандарт, орчин үеийн жишгийг хүссэн хүсээгүй дагах л хэрэгтэй. Ядаж л малчин өрх бүр малаа үзлэг шинжилгээнд бүрэн хамруулж, шаардлагатай вакциныг цаг тухайд нь хэнээр ч шахаж шаардуулахгүй хийлгэдэг хэвшилд сурмаар байна. Үнэхээр өвс тэжээлийн доройтолд орсон мал байгаа бол тусгай арчилгаа сувилгаа гээд эзэн хүний сэтгэл зүтгэлээс шалтгаалах ажил бас олон. Гэтэл амьжиргаа муутай зарим малчин буянт малаа үзлэг шинжилгээнд хамруулж вакцинжуулах нь байтугай дөрвөн улирлын турш нэг л нутаг дээрээ бүр суурьшдаг болжээ. Ийм хүмүүс малынхаа удмын санд санаа зовохгүй гэдэг нь тодорхой. Эцэст нь хүний өөрийнгүй ойр орчимд байгаа мал гэнэт өвчилнө. Муу хүн нутаг усандаа балагтай гэгч энэ буюу. Улмаар улс Монголынхоо хөгжил дэвшлээс хойш татаад эхэлж байна. Хөдөлмөрийн баатар Ц.Намхайнямбуу “Баатарын алтан соёмбо хоттой хонин дотор маань байсан юм билээ” гэж нэгэн цагт хэлж байсан юм. Тиймээс дор бүрнээ хичээж ухаантай л амьдарцгаая!

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




ОХУ-ын зохиолч
Виктор Трифонович Слипенчук

# ДЭЛХИЙ

# Нэг зууны дараа АНХ УДААГАА НАР БҮТЭН ХИРТЛЭЭ








Б.ДАВААХҮҮ

Америк тивийг дамнан энэ сарын 21-ний өдөр 100 жилийн түүхэнд анх удаагаа нар бүтэн хиртэж, хэдэн сая хүн байгалийн ховор үзэгдлийг харж баясчээ.

Номхон далайн баруун эрэгт орших Орегон муж улсаас Атлантын далайн зүүн эрэгт орших Өмнөд Каролина муж улс хүртэлх зурвас бүсэд 1918 оноос хойш анх удаагаа бүтэн нар хиртэлт ажиглагдсан байна. Нар хиртэлтийг ойролцоогоор 200 сая хүн үзэж сонирхжээ. Энэ нь түүхэн дэх хамгийн олон хүн ажигласан, хамгийн их баримтжуулсан нар хиртэлт боллоо гэж НАСА агентлаг мэдээллээ. Ореган муж улсын 7000 хүн амтай Мадрас сууринд л гэхэд нар хиртэлтийг харахаар 100 гаруй мянган хүн цугласан байсан аж. Иллинойс муж улсын Карбондейл хотод бүтэн нар хиртэлт хамгийн урт буюу 22 минут 44 секунд ажиглагдсан гэнэ. "Үнэхээр гайхамшигтай байлаа. Зуун жилд ганц тохиолдох байгалийн ховор үзэгдлийг харлаа. Миний амьдралын мартагдашгүй мөчүүдийн нэг болж өнгөрлөө" гэж Миссури муж улсаас Иллинойсоос ирж нар хиртэлтийг үзсэн Грегг Толанд ярьжээ. Нар хиртэлт анх Ореган муж улсын Линкольн хотод орон нутгийн цагаар даваа гарагийн өглөөний 10:16 цагт ажиглагдсан бол хамгийн сүүлд Өмнөд Каролина муж улсын Чарльстон хотод үдээс хойш 2:48 цагт ажиглагджээ.

Харин Ореган мужид нар хиртэж эхэлснээс хойш нэг цаг 30 минутын хугацаанд Идахо, Монтана, Вайоминг, Небраска, Канзас, Айова, Миссури, Иллинойс, Кентакки, Теннесси, Жоржиа, Хойд Каролина, Өмнөд Каролина гээд бүс нутаг даяар ээлж дараалан нар хиртсэн байна. Нар хиртэлтийг жижиг тосгоноос эхлээд томоохон цэцэрлэгт хүрээлэн гэх мэт байгалийн ховор үзэгдлийг ажиглах боломжтой газар бүрт маш олон хүн цугларч, тусгай нүдний шил ашиглан сонирхож байжээ. Иллинойс мужийн Карбондейл хотынхон өөрсдийгөө "Америкийн нар хиртэлтийн огтлолцох цэг" хэмээн нэрлэжээ. Тус хотод 2024 онд ч гэсэн нар хиртэлт болох юм байна. Улмаар түүнд бэлтгэн өөрсдийгөө ийн нэрлэжээ. Хотын захиргаанаас энэ удаагийн байгалийн онц содон үзэгдэлд зориулж, нийт 60 гаруй мянган машины зогсоолыг бэлтгэсэн байна.

АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп ч гэр бүлийнхээ хамт нар хиртэлтийг үзэж сонирхжээ. Тэрбээр Вашингтон ДС хотод гэргий Милания Трамп, хүү Барроны хамт нарны хүчтэй туяанаас нүдийг хамгаалах тусгай зориулалтын шил зүүн байгалийн үзэгдлийг үзэж сонирхсон байна.

Олон улсын сансрын буудалд байрлаж буй Италийн сансрын нисгэгч Паоло Несполи нар хиртэлтийн дэлхий рүү тусгаж буй сүүдрийг гэрэл зурагт буулгаж авчээ. Нар, дэлхий хоёрын хооронд сар орж, нар бүхлээрээ буюу зарим хэсэг нь дэлхийн зарим хэсгээс харахад саранд халхлагдаж, харагдах-гүй болох үзэгдлийг нар хиртэлт гэдэг юм. Дэлхийгээс харахад, нар хиртэх үед сар нь нартай адил хэмжээтэй болдог. Энэ нь сар голчоороо нарнаас 400 дахин жижиг боловч дэлхийд нарнаас 400 дахин ойр оршдогтой холбоотой гэнэ. Ингээд нар сар давхацсанаар тэнгэр харанхуйлдаг байна. Дараагийн бүтэн нар хиртэлт АНУ-д 2024 онд болох аж. Харин америкчууд 2045 оноос нааш хоёр эрэг дамнасан бүтэн нар хиртэлтийг харахгүй нь ээ. Тэгвэл АНУ-аас гадна гэвэл 2019 онд Номхон далайн өмнөд хэсэгт Чили болон Аргентинд нар бүтэн хиртэх ажээ.

## Испанид эрэн сурвалжлагдаж байсан эр амиа алдлаа

Испанийн Барселона хотод террорист халдлага үйлдэж, 13 хүний аминд хүрч, 100 гаруй иргэнийг шархдуулсан гэмт этгээд амиа алджээ. Тэрбээр халдлагын дараа хэргийн газраас зугтаж, цагдаагийнхан өргөн хүрээнд эрэн сурвалжилж байсан юм.

Террорист халдлага үйлдсэн Монакко гаралтай эр цагдаагийнхантай мөргөлдөх үедээ тэсрэх бодис бэхэлсэн бүстэй ижил зүйлийг биедээ зүүсэн байжээ. Улмаар цагдаа нар болзошгүй аюулаас сэрэмжлэх үүднээс түүнийг буудан хөнөөсөн байна. Нас барсан этгээдийг Янес Абоякуб гэдэг бөгөөд 22 настай байжээ. Испанийн Каталони мужийн цагдаагийн газрын албан ёсны твиттер хуудаст "Сэжигтэн Барселонагийн Субиратст амиа алдсан" гэж нийтэлсэн байв. Мөн "Сэжигтэн тэсрэх бөмбөг шиг зүйл бүсэлсэн байсан. Гэвч дараа нь харахад тэр нь хуурамч байсан" гэж цагдаа нар тайлбарлажээ.

Гэмт хэрэгтэн тухайн үед хутгаар зэвсэглэсэн байсны зэрэгцээ "Аллах бурхан хамгийн агуу" хэмээн хашгирч байсан гэнэ. Янес Абоякуб энэ сарын 17-нд Барселонагийн Лас Рамблас гудамжинд бүхээгтэй машин жолоодон явган зорчигчдыг дайрсан юм. Үүний дараа Камбрилст ч мөн халдлага үйлдсэний улмаас нэг эмэгтэй нас баржээ.

Цагдаагийн газраас мэдээлснээр, тэрээр зугтаж явахдаа 34 настай нэгэн эрэгтэйн амийг бүрэлгэж, машиныг нь дээрэмдэн зугтсан байна. Ингэснээр, түүний гарт нийтдээ 15 хүн амиа алджээ.

## Балбын анхны парламентын сонгууль арваннэгдүгээр сард болно

Хаант засаглалаас Бүгд найрамдах улсын тогтолцоонд шилжиж, хоёр жилийн өмнө шинэ Үндсэн хуулиа батласан Балба ирэх арваннэгдүгээр сард анхны парламентын сонгуулиа явуулахаар болжээ. Энэ талаар өчигдөр тус улсын Засгийн газраас мэдээлсэн байна.

Мэдэгдэлд "Парламентын доод танхимын сонгуулийг арваннэгдүгээр сарын 26-нд товлолоо" гэсэн байв. Тус улс 10 жил иргэний дайнтай байсны эцэст 2008 онд хаант засаглалыг халсан юм. 2015 онд баталсан Үндсэн хуульд зааснаар, Балба нь одоо долоон мужаас бүрдэх Бүгд найрамдах улс юм. Шинэ Үндсэн хууль батлахаас өмнө тус улсын улс төрийн байдал тогтворгүй, намууд засгийн эрхийн төлөө зөрчилдөөнтэй байсан билээ. Арваннэгдүгээр сард бүх нийтийн сонгууль хийсний дараа тус улс шинэ Ерөнхий сайдаа сонгоно. Тус улсад 2015 оны дөрөвдүгээр сард болсон газар хөдлөлтийн улмаас 9000 хүн нас барсан. Түүнээс хойш эвдэрч, нурсан байшин барилгыг дахин барих, дэд бүтцийг сэргээх ажил хоцрогдолтой байгаа. Харин тус улсын шинэ Засгийн газар улсынхаа хөгжлийн хурдасгаж чадах эсэх нь ажиглагчдын анхаарлыг татаж байна.

## А.Меркель Турктай гаалийн холбоо байгуулах хэлэлцээг үргэлжлүүлэх боломжгүй гэв

Германы канцлер Ангела Меркель гаалийн холбоо байгуулах тухай Европын холбоо, Туркийн хооронд хийгдэж буй хэлэлцээг үргэлжлүүлэх боломжгүй гэж үзжээ. Энэ тухай тэрбээр лхагва гарагт ХБНГУ-д нэртэй блогчидтой сонгуулийн кампанит ажлын хүрээнд уулзах үеэрээ мэдэгджээ. "Ямар ч тохиолдолд бид одоогийн байдлаар Турктэй гаалийн холбоог өргөжүүлэхгүй. Цаашид гүнзгийрүүлэх тухай бол бүр ч ярилтгүй" хэмээн А.Меркель онцлон дурьдаад "Бидэнд саналын олон зөрүүтэй асуудал байгааг нуух шаардлагагүй" гэлээ. Түүгээр ч барахгүй "Турк улстай харилцаа холбоо муу байгаа энэ нөхцөлд бид хүмүүсээ Туркид хөрөнгө оруулалт хийх болон чөлөөтэй аялахдаа болгоомжтой байхыг байнга сануулж байгаа. Турк улс бол зөвхөн Ерөнхийлөгч Эрдоган болон түүний Засгийн газар биш юм. Бид Туркийн Үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг дэмжээгүй 50 хувийн эрх ашгийг ч бас бодолцох ёстой" гэсэн байна. ХБНГУ-ын ГХ-ийн сайд Зигмар Габриэль өнөөгийн нөхцөл байдалд гаалийн холбоо байгуулах тухай Европын холбоо, Туркийн хооронд хэлэлцээг үргэлжлүүлэх боломжгүй гэдгийг мөн батлан хэлжээ.



## Хар тамхины эсрэг дайнаа зогсоохыг шаардлаа

Филиппиний нийслэл Манила хотод Ерөнхийлөгч Родриго Дутертег хар тамхины эсрэг зарласан дайнаа зогсоохыг шаардан мянга мянган хүн жагсчээ. Хүний эрхийн төлөө тэмцэгчид, залуучууд болон шашны бүлэглэлүүд халуун орны үргэлжилсэн ширүүн бороог үл хайхран 1986 оны хувьсгалд зориулсан дурсгалын хөшөөний дэргэд цугларан хар тамхины эсрэг дайн болон хүний амь хөнөөх ажлаа зогсоохыг Р.Дутертед уриалсан байна.

Жагсаалын дараа Ерөнхийлөгч Р.Дутерте мөн мэдэгдэл хийжээ. Тэрбээр түүний хар тамхины эсрэг хийж буй дайны бодлогод хууль зөрчсөн, хүчирхийлсэн тохиолдол гарсан байхыг үгүйсгэхгүй байгаагаа онцолсон аж. Жагсагчид цаазаар авах ялын гүйцэтгэл болон цагдаа нарын гүйцэтгэх ажиллагааг шалгах бие даасан мөрдөн байцаалт явуулахыг шаарджээ. Ерөнхийлөгч эдгээр хүмүүсийн үхэлд хариуцлага хүлээх ёстой гэж тэд үзэж байгаа юм. Жагсагчид Филиппин улсын далбаа барьж, мөн "Фашистыг эсэргүүцэж байна", "Аллагаа зогсоо", "Бид тэмцэх болно" зэрэг бичиг бүхий самбар барин жагссан байна.

"Шийтгэгч" хочит Родриго Дутертегийн эхлүүлсэн хар тамхины эсрэг дайнаар 13 мянган хүн амиа алджээ.

## "Johnson and Johnson" нөхөн төлбөр олгохоор болов

АНУ-ын Калифорни мужийн Лос-Анжелес хотын шүүх АНУ-ын эм, өдөр тутмын хэрэгцээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх томоохон компани болох "Johnson and Johnson" компанид 470 сая ам.долларын торгууль ногдуулах шийдвэр гаргалаа.

Эдүгээ 63 настай Эва Эчеверриа гэх эмэгтэй өнгөрсөн жилийн долдугаар сард шүүхэд тус компанийн үйлдвэрлэсэн талькийг хэрэглээд өндгөвчний хорт хавдар туссан хэмээн гомдол гаргасан юм. Бүсгүй олон жилийн турш бэлэг эрхтний орчимдоо талькийг түлхэн хэрэглэдэг байжээ. Гэвч, дараа нь өндгөвчний хорт хавдар туссан аж. Гэхдээ "Johnson and Johnson" компанийн тал шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул давж заалдах шатны шүүхэд хандана гэдгээ мэдэгдээд байна.


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017-08-21**

Тендер шалгаруулалтын нэр: **Эрдэнэ багийн Баян талын карьерийн 2 хэсгийн нөхөн сэргээлт /9.05 га/**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОР-107/2016**

**Орхон аймгийн засаг даргын тамгын газар** эрх бүхий тендерт оролцогчдоос Э**рдэнэ багийн Баян талын карьерийн 2 хэсгийн нөхөн сэргээлт /9.05 га/**–ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: **Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байх**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жилийн /2016, 2015 он/ аудитлагдсан тайланг ирүүлнэ.**

Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх.**

Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай: **Нөхөн сэргээлт хийх**

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн **[1%]** төгрөгийн дүнтэй цахим тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 09-р сарын 21 ний өдрийн 08 цаг 30 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 09-р сарын 21-ны өдрийн 09 цаг 00 минутанд** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймгийн ОНӨГ, Утас:70358570**

# ОНЦЛОХ ХУУДАС

## Speak out



# ЗҮҮН ЭРГЭХГҮЙ БАЙХ НЬ ТҮГЖРЭЛ НЭМЖ БАЙНА

Г.ГАНЧИМЭГ

*Машин барьж буй иргэд энэ сарын 15-наас эхлээд зүүн дөрвөн замаас баруун дөрвөн зам хүртэл зүүн тийш эргэхээ больсон. Энэ журам хэрэгжиж эхэлсэн анхны өдрөөс л хүмүүс автомашинтай замын хөдөлгөөнд оролцохдоо зүүн тийш эргэж чадалгүй байсаар ажлаасаа хоцрон будилж байлаа. Эхлээд учраа ололгүй иймэрхүү байдал үүсч байсан бол одоо төв зам дагасан туслах замууд дээр цаг үргэлж автозамын хөдөлгөөн түгжирч байна. Зарим туслах зам дээр явган хүн ч чөлөөтэй зорчихын аргагүй болтлоо хөдөлгөөн нягтаршжээ. Үүнээс болоод төлөвлөсөн уулзалт, ажлаасаа байнга хоцорч буйдаа иргэд бухимдалтай байгаа юм. Одоохондоо ч яах вэ. Харин удахгүй сургууль, цэцэрлэгийн хичээлийн шинэ жил эхлэхээр замын хөдөлгөөн юу болох бол. Иргэдийн олонхи нь "Энэ нь зөвхөн жолооч нарт хамаатай асуудал биш. Жолоо барьдаг, барьдаггүй, машинтай, машингүй нь хамаагүй ажил сургуультай хүн бүрийн л асуудал болоод байна. Тиймээс энэхүү шийдвэрээ эргэн харж, хуучин хэвэнд нь оруулбал зүгээр" хэмээн байр суурь, үзэл бодлоо илэрхийлж байна.*



### Б.Ганбат: Туслах замууд дээр ачаалалтай байна

*/Чингэлтэй дүүргийн иргэн/*

-Яг төв замдаа бөглөрөл үүссэн үед зүүн дөрвөн замаас баруун дөрвөн зам хүртэл зүүн эргэхгүй гэдэг журам зүгээр байх. Гэхдээ удахгүй хүүхдүүдийн хичээл сургууль эхэлнэ. Тэр үед замын хөдөлгөөний ачаалал эрс ихэсдэг шүү дээ. Одоохондоо туслах замууд дээр их ачаалалтай байна. Харин есдүгээр сарын 1-нээс хойш хаа сайгүй бөглөрч, замын түгжрэл илт нэмэгдэх болов уу. Одоогоор туслах замууд их гацаатай байна. Төв замаараа бол ямар ч түгжрэлгүй шулуун явж болж байна. Гэхдээ туслах замаас төв зам руу орж ирж буй машинууд ихээхэн түгжрэл үүсгэж байна шүү дээ.

### Ц.Баттөмөр: Хотын төв рүү орох аргагүй болжээ



*/Сонгинохайрхан дүүргийн иргэн/*

-Төв замаар явдаггүй хүн, тийшээ очдоггүй зам гэж байхгүй. Зам салж нийлж, хүн орж гарч л таарна шүү дээ. Тиймээс энэ журмыг дэндүү буруу шийдвэр болсон гэж үзэж байна. Одоо туслах замуудын ачаалал, түүн дээрх автомашины түгжрэл хэрээс хэтэрлээ. Өмнө нь бас ч гэж туслах замуудын түгжрэл гайгүй л байсан шүү дээ. Таски унаанд сууж байгаа хүмүүс ч их бухимдаж байна. Мөнгөө төлсөн хүн хүссэн газраа санаагаараа хүрчихэж болохгүй, заавал тойрч давхиад байхаар арга ч үгүй биз. Зүүн эргээд л орчих газрыг чинь бүтэн тойрч байж очно. Тэгээд ингэж цаг хугацаа үрчихээд илүү мөнгө төлөхөөр хэн дуртай байх вэ. Хотын төв рүү орох аргагүй болжээ.



### Л.Номингэрэл: Түгжрэлийг улам ихэсгээд байгааг ойлгохгүй нь

*/Баянгол дүүргийн иргэн/*

-Би хувьдаа зүүн эргэхгүй гэдгийг буруу шийдвэр гэж бодож байна. Энэ нь төв зам дагасан туслах замуудын ачааллыг эрс ихэсгэж байгаа юм. Хоёрдугаарт, би хаашаа ч явсан тойруу замыг сонгодог болоод байна. Ингэхээр чинь наад зах нь шатахуун тосонд үрэлгэтэй, цаашлаад цаг хугацаанд гарзтай энэ шийдвэр хэнд ч, ямар ч хэрэггүй. Одоо нэг л төв зам руу орчихвол эргэх боломжгүй болчихоод байгаа юм. Төв зам руу орохгүй тойрч явж байна гээд туслах зам дээр түгжрэл үүсгээд байна шүү дээ. Иймэрхүү байдлаар автозамын түгжрэлийг улам ихэсгэх журам гаргасныг ерөөсөө ойлгохгүй байна.



### Т.Далайтогтох: Төлөвлөсөн цагтаа бараагаа хүргэж чадахгүй байна

*/Чингэлтэй дүүргийн иргэн /*

-Би хотын төвөөр явж, түгээлт хийдэг ажилтай хүн. Баруун дөрвөн замаас зүүн дөрвөн зам хүртэл бас ч гэж урт зам шүү дээ. Гэтэл одоо ажлаа хэвийн явуулж чадахаа больсон. Тойрч давхисаар байгаад хамаг цагаа барж байна. Өмнөх шигээ төлөвлөсөн цагтаа бараагаа хүргэж чаддаггүй. Тухайлбал, XIII хорооллоор эргэж чадахгүй, замын цагдаагаар тойрч давхисаар байгаад л IV дэлгүүр рүү арай гэж орж ирнэ шүү дээ. Тэгээд бороо устай, түгжрэл ихтэй ажлаа явуулахад хэцүү л байна. Өөрөөр хэлбэл, А цэгээс Б цэг хүрэхэд өмнө нь 30 минут зарцуулдаг байсан бол одоо хамгийн хурдандаа 45 минут, тэгээд нэг цаг болж байж хүрч байна шүү дээ. Бид өмнө нь 19-20 цагт ажлаасаа буудаг байсан бол одоо 21-22 цаг хүргэж байна.



### Б.Очирбат: Явган алхаж сурах хэрэгтэй

*/Баянгол дүүргийн иргэн/*

-Манайхан нэг ийм муухай зантай болчихож. Юм болгон дээр эвэр хошуулж яах юм бэ. Би энэ журмыг зөв шийдвэр гэж дэмжиж байгаа. Сав л хийвэл машинд суудаг муухай зангаасаа одоо сал. Явган алхаж сурах хэрэгтэй шүү дээ. Эрүүл мэндэд нэмэртэй. Автобус ч түгжрэхгүй аятайхан болно. Хүн болгон машин унаж замын хөдөлгөөнд түгжрэл үүсгэж байснаас бүгдээрээ нийтийн тээврээрээ үйлчлүүлж хэвшвэл зүгээр. Өвлийн хүйтэнд, хальтиргаа гулгаатай зам дээр түгжрэл үүсгэхгүй харин ч нүдээ олсон зөв шийдвэр болсон.



### А.Наранбат: Гэртээ орохын тулд хотын төвийг бүтэн тойрч байгаа

*/Баянгол дүүргийн иргэн/*

-Төв зам дагуу байрлалтай газарт ажиллаж, тэр хавьд амьдардаг хүмүүст энэ журам илүү хүндрэлтэй тусч байгаа. Түүнээс биш төв замаараа давхиад өнгөрч байгаа хүн үүнийг анзаарах ч үгүй. Түгжрэлгүй замаар шулуун шуурхай давхиж байгаадаа олзуурхаад л өнгөрнө. Гэхдээ л дийлэнхэд нь хүндрэлтэй байна. Цэцэг төв рүү очихын тулд хаа байсан Жуковоор эргэнэ шүү дээ. Хотын төвд гэртэй хүмүүс өглөө ажилдаа явах, орой харихын тулд бүтэн тойрч байж л очиж байгаа. Тиймээс тэдэнд хүндрэлтэй байгаа юм билээ. Миний хувьд хотын төвөөр нэг их яваад байдаггүй. Гэхдээ л замын түгжрэл нэмэгдэж, ачаалалтайболсныганзаарчбайгаа. Төв замын хөдөлгөөн сийрэгжсэн ч гэлээ туслах замуудын ачаалал улам ихэссэн шүү дээ.



### С.Зоригтбаатар: Энэ түгжрэл одоо хэд дахин нэмэгдэнэ

*/Сонгинохайрхан дүүргийн иргэн/*

-Туслах замууд бүгд түгжирч байна. Тиймээс энэ журам надад таалагдахгүй байгаа юм. Жаахан яваад л зүүн эргээд орчих газарт чинь заавал бүтэн тойрч байж очихоор чинь таксинд суусан хүмүүс дургүйцэж, бүгд л уур уцаартай бууж байна. Зорчигчид ихэнхдээ л энэ журмыг эсэргүүцэж байгаа. Одоо замын ачаалал гайгүй байдаг үе шүү дээ. Удахгүй намар болохоор сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдээ зөөх гээд замын хөдөлгөөн эрчимжинэ. Тэр үед энэ түгжрэл хэд дахин нэмэгдэх нь байна шүү дээ.

### Г.Мягмарсүрэн: Замын хөдөлгөөнд оролцоход хэцүү болсон



*/Сүхбаатар дүүргийн иргэн/*

-Зүүн тийш эргэхгүй болсноос хойш замын хөдөлгөөнд оролцоход их хэцүү байна. Байнга түгжирдэг болсон. Бүгдээрээ дөрвөн замаа тойрохоор туслах замууд дээр түгжрэл үүсгэж байна. Нэг л төв зам руу орчихвол эцэс хүртэл нь явахаас аргагүй. Ингэхгүй гэвэл тойрч давхисаар байгаад товлосон ажлаасаа хоцорч, уулзахаар тохирсон хүнийхээ өмнө эвгүй байдалд орж байна.

### А.Төгсөө: Өвлийн хүйтэнд хүүхэд осговол яана



*/Хан-Уул дүүргийн иргэн/*

-Зүүн тийшээ эргэхгүйгээр замын хөдөлгөөнд оролцоно гэдэг бидэнд их хүндрэлтэй л байна. Бид өдөр болгон дэлгүүрүүдэд бараа хүргэж өгдөг ажил хийдэг. Энэ журмаа эргэн харж гаргасан шийдвэрээ өөрчлөхгүй бол хүмүүс их бухимдалтай байна. Зөвхөн жолооч нарт ч биш энэ нь хүн бүхэнд хамаатай асуудал шүү дээ. Тухайн хүн машинтай, машингүй нь хамаагүй. Өглөө ажилдаа ирж, орой гэртээ харина биз дээ. Тэр үедээ хувийн тэрэгтэй нь машинаа унаад, машингүй нь такси бариад ирж байгаа. Гэтэл аль нь ч ялгаагүй тойрч, тойрч нэг юм зогсоно. Илүү зардал гаргасан дэмий шийдвэр болсон. Бид аль болох дөт замаар явж, олон газраар орж ажлаа амжуулахыг л хүснэ шүү дээ. Гэтэл энэ хүсэл зорилтод маань хаалт боолт болж байгаа юм. Сургууль соёлын хүүхдэд ч ялгаагүй бэрхшээлтэй. Хоцролт ихтэй болно. Хүүхдүүдийг хичээлээсээ хоцорсон гээд сургууль, багш нар нь оруулахгүй. Ингэвэл өвлийн хүйтэнд их хэцүү. Хүүхдүүд даарч бээрээд осговол яана.

### Ч.Зоригтбаатар: Машин урагшаа явахгүй байна

*/Сүхбаатар дүүргийн иргэн/*



-Ер нь IV дэлгүүр, Засгийн газрын ордны хойд уулзвар байнга битүү, түгжрэлтэй байдаг болсон. Бүх машин тэр уулзвараар орж ирэхийн тулд дандаа түгжирч байна. Төв зам бол хоосон байна. Яах вэ, цөөн тооны эргэхгүй гэсэн машинууд яваад өнгөрч байна. Гэхдээ амьдрал дээр ямар ч эргэлт хийдэггүй машин гэж байхгүй шүү дээ. Тиймээс туслах зам дээр их эргэж байна. Тухайлбал, Бөхийн өргөө рүү ороод тойрог дээр нь эргэчихэж байгаа юм. Эсвэл Гадаад харилцааны яам руу ороод буцаж эргэн ачаалал үүсгэж байна шүү дээ. Энд тэндгүй ачаалал үүсгэж, зам түгжирч байна шүү дээ. Үнэндээ Сүхбаатарын талбайн баруун, зүүн талын зам хоосон л байдаг байсан. Гэтэл одоо битүү түгжрэлтэй болчихсон, машин урагшаа явахгүй байна.

### Б.Аззаяа: Мэдэхгүй хүмүүс будилсаар л байна

*/Сонгинохайрхан дүүргийн иргэн/*

-Хуучнаараа л байсан бол дээр байсан юм. Гэтэл одоо зарим хүн ийм журам гарсныг нь ч мэдэхгүй зүүн тйиш эргээд, эсвэл төв зам руу орчихоод дуустал нь явахаас аргагүйдэн будилж байна шүү дээ. Хүмүүсийн уурыг барж, цаг хугацааг нь дэмий үрж байна.



# ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

## Аймгаас мэдээлж байна

СЭЛЭНГЭ АЙМАГ

### ААШТ-д оролцсон тамирчдаа хүлээн авч уулзлаа

Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон өсвөрийн тамирчдаа өчигдөр хүлээн авч уулзлаа. Тайландын нийслэл Бангкок хотноо долдугаар сарын 21-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Ази тивийн аварга шалгаруулах өсвөрийн чөлөөт бөхийн тэмцээнд тус аймгийн хоёр тамирчин дасгалжуулагч багш Б.Энхбатын хамт амжилттай оролцсон билээ. Тэмцээнд 18 орны 340 гаруй тамирчин хүчээ сорин өрсөлдсөн бол Монгол Улсаас 20 тамирчин оролцжээ. Азийн аваргын 49 кг-ын жинд спортын сургуулийн 12 дугаар ангийн сурагч Д.Отгонжаргал хүрэл медаль хүртсэн бол 70 кг-ын жинд Сүхбаатар сумын нэгдүгээр сургуулийн 12 дугаар ангийн сурагч Ц.Хулан шагналт тавдугаар байрт шалгарсан байна. Тамирчид эдүгээ ирэх есдүгээр сарын 04-08-ны өдрүүдэд Грек улсын Афин хотноо зохион байгуулагдах өсвөр үеийн чөлөөт бөхийн дэлхийн аваргад оролцох бэлтгэлээ хангаж байгаа аж. Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил тамирчдын тэмцээн уралдааны зардлыг шийдэж өгснийг тэд амжилтаар ийнхүү хариулсан байна. Уулзалтын үеэр аймгийн дарга дэлхийн аваргад оролцох зардлыг шийдвэрлэхээ илэрхийлж, тэмцээндээ амжилттай оролцохыг хүслээ. Дэлхийн аваргад манай улсаас эрэгтэй эмэгтэй 20 тамирчин, гурван дасгалжуулагч багшийн хамт оролцох ажээ.

### Сэлэнгэ аймгийн 17 сумын мал эмнэлэг, үржлийн тасаг мотоцикльтой болжээ



ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэнгийн санаачилгаар аймаг, нийслэлийн ХХААГ, сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтнүүдэд салбарын бодлого зорилтыг хэрэгжүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг үр дүнтэй бодитой өрнүүлэхэд анхаарах, ажлын уялдаа холбоог бэхжүүлэх, туршлага солилцох зорилготой Төвийн бүсийн сургалт энэ сарын 19-21-ний өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд амжилттай зохион байгуулагдлаа. Төвийн бүсийн сургалтад нийслэл, Дундговь, Сэлэнгэ, Төв, Дархан аймгийн ХХААГ, сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн 200 гаруй мэргэжилтэн хамрагдлаа. Сургалт зөвлөгөөний үеэр малын гоц халдварт өвчний үеийн "Хээрийн мал эмнэлэг дэлгэх" үзүүлэх сургуулилт болж, малын гоц халдварт өвчин гарсан үед анхан шатанд ямар арга хэмжээ авах, илрэх шинж тэмдэг, хорио цээр тогтоосон бүс нутагт хэрхэн ажиллах зэргийг Онцгой байдлын Ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын газар, Сэлэнгэ аймгийн ХХААГ хамтран үзүүллээ. Энэ үеэр Сэлэнгэ аймгийн 17 сумын Мал эмнэлэг үржлийн тасагт мотоцикл гардуулан өгсөн нь анхан шатанд ажиллаж буй мэргэжилтнүүдээ дэмжсэн сайхан үйл ажиллагаа боллоо.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

### Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлгийг ашиглалтад хүлээн авлаа

Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлгийн их засварын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан байна. Тодруулбал, тус аймгийн удирдлагууд Орон нутгийн хөгжлийн сангийн 79.9 сая төгрөгөөр Гүнгийнхэн ХХК-тай гэрээ байгуулан, аймгийн Нэгдсэн эмнэлгийн их засвар /дотор, мэс засал, гэмтэл, мэдрэлийн тасаг/-ын ажлыг гүйцэтгүүлжээ. Түүнчлэн энэ сарын 21-ний өдөр Улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэсэн байна.

ДОРНОГОВЬ АЙМАГ

### Данзанравжаагийн нэрэмжит яруу найргийн наадам болов

Говийн тавдугаар ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн нэрэмжит Дэлхийн яруу найргийн наадмыг энэ сарын 19-20-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Монголын Соёл, Яруу найргийн академитай хамтран зохион байгууллаа. Уг наадмын арга хэмжээнд дэлхийн 40 орчим орны 160 гаруй нэртэй яруу найрагч, зохиолч, нийтлэлч, орчуулагч, урлаг соёлын зүтгэлтэн болон манай улсын 60 орчим яруу найрагч оролцлоо. Олон улсын Яруу найргийн наадмын нээлтэд Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, ИТХ-ийн төлөөлөгч Ж.Болор-Эрдэнэ, АЗДТГ-ын дарга Б.Ганзориг, АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ч.Байгалтуяа нар оролцож, аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нээж үг хэллээ. Тэрбээр хэлсэн үгэндээ Монгол Улсыг төдийгүй манай Дорноговь аймгийг сурталчлах, үндэсний түүх, өв соёл, бахархлаа илэрхийлэх, таниулах, гадаадад сурталчлах алтан боломж бол энэхүү "Дэлхийн яруу найрагчдын наадам" гэдгийг тодотгосон юм. Мөн үүгээр дамжуулан дэлхийд нэртэй сая сая уншигчидтай зохиолч, яруу найрагчид Монгол орны тухай төсөөллөө бодит болгож, Монголын түүх, соёл, байгаль, ард түмний тухай шүлэг зохиол бичиж, өөр өөрийн хэлээр нийтлүүлж, говь нутгийн байгалийн болон соёлын өвийг олон улсад таниулан сурталчлах өндөр ач холбогдолтой соёлын, аялал жуулчлалын томоохон арга хэмжээ болж байгааг онцлон тэмдэглэлээ.

Яруу найргийн наадмын хүрээнд гадаад, дотоодын зочид төлөөлөгчид говь нутгийн мал аж ахуй, ахуй амьдрал, таван хошуу мал, тэмээний соёлтой танилцсан байна. Мөн бэсрэг наадам болж дааганы уралдаан, бөхийн барилдаан, үндэсний сур харваа, шагайн харваа зэргийг үзэн сонирхож, Засаг даргын Хүндэтгэлийн хүлээн авалтад оролцож, "Оддын доорх Яруу найргийн уншлага"-д орон орны яруу найрагчид шүлэг зохиолоо уншин, дэлхийн Энергийн төв болсон газраар аяллаа.

Б.ДАВААХҮҮ



# ТЕХНИК НЬ ЭЛЭГДСЭН Ч, ТҮЛШ АЛДААГҮЙ

Нийслэлээс зүүн тийш 130 гаруй км-т хамгийн алслагдмал дүүрэг Багануур байрлана. Нэгэн үе "Уурхайчдын хот", эдүгээ "Аз жаргалын хот" хэмээн нэрлэгдсэн тус дүүрэг 1980 онд "Багануур"-ын уурхайд түшиглэн байгуулагдаж байсан түүхтэй.

Харин төвийн эрчим хүчний системийн харьяа дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зориулалтаар 1978 онд байгуулагдсан Багануур ХК эдүгээ 39 дэх жилийнхээ намартай золгож байна.




Байгуулагдсан цагаасаа хойш улсынхаа гал голомтыг манаж, дүүргийнхээ хөгжлийн түүчээ болж яваа тус уурхай улсын нүүрсний хэрэглээний 60, эрчим хүчний нүүрсний 70 хувийг дангаараа хангадаг билээ. Түүхийн хуудас эргүүлсэн 30 гаруй жилийн түүхэнд тус компани "гал алдсан" удаа үгүй. Угаасаа Багануурын нүүрс ахуйн хэрэглээнд хамгийн тохиромжтой бөгөөд өнгөн хэсгийнх нь нүүрсний илчлэг бага байдаг бол доошлох тусам илчлэг чанар улам ихэсдэг аж. Тиймээс нүүрсээ холиод зах зээлд гаргадаг юм билээ. Уурхай жилд 4-6 сая тонн нүүрс гаргах хүчин чадалтайгаар байгуулагдсан бол эдүгээ уурхай жилдээ өнөөдрийн нүүрсний хэрэгцээг хангах зорилгын хүрээнд жилдээ хязгаарлагдмал байдлаар буюу 3.8-3.9 сая тонн нүүрс олборлож байна. Гэхдээ цаашид борлуулалтаа нэмэх бүрэн боломжтой гэдгийг "Багануур" ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Номинчулуун онцолж байсан юм. Тэрбээр "Эрээн болон Бээжин хотын наад захын хотуудаас санал ирүүлсэн. Гэхдээ их хэмжээгээр буюу ойролцоогоор жилдээ таван сая тонн нүүрс авах санал тавьсан учраас хүчин чадлаа нэмэх болж байгаа юм. Одоогийн нөөц боломжоор бол хэцүү л дээ. Манай багийн хувьд 2017 онд ажил аваад нийгмийн сайн сайхан руу чиглэсэн аян зохион байгуулах, эко орчныг бүрдүүлэхэд нэлээд анхаарч ажиллаж байна. Үүний дагуу 100 мянган тонн сайжруулсан түлш боловсруулах үйлдвэр байгуулах төсөл бичсэн. Туслан гүйцэтгэгч компанитайгаа хамтарч, техник эдийн засгийн үндэслэлээ боловсруулсан. Үүнийгээ Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, техникийн зөвлөлд хүргүүлсэн. Харамсалтай нь, дөрөвдүгээр сард техник, эдийн засгийн үндэслэлээ өгсөн ч өнөөдрийг хүртэл хариу нь гараагүй байна" хэмээсэн юм. Түүнчлэн, эднийх нүүрс баяжуулах Солонгос, Герман технологи хийгээд цаашид өөрсдийн нөөц боломжоор хэрхэн баяжуулах арга технологийг судалсаар байгаа аж.



## Хүнээ дээдлэгч компани

"Багануур" ХК 1150 гаруй ажилтантай. Өөрөөр хэлбэл, мянга гаруй ажилтны цаана мянга гаруй өрх айлын амьдралыг давхар авч явдаг. Аливаа байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлгөгч хүч нь яах аргагүй хүний нөөц байдаг. Тэгвэл "Багануур"-ын уурхайнхан ажилтнаа хүн, байгууллагын үнэт капитал гэдэг утгаар нь дэмжиж ажилладаг юм билээ. Тус компанийн удирдлагын баг "Хүнийг дээдэлж байж, хүндлэлийг олж авна" гэх зарчмыг баримталдаг гэнэ. Тиймдээ ч, ажилтнуудынхаа хандлагыг эерэг болгох, хувь хүн талаас нь хөгжүүлэхээс эхлээд гэр бүлд нь хүртэл анхаарал хандуулдаг байна. "Багануур" компанийн хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал О.Туяа "Манайх ажилтнуудынхаа гэр бүлд хандсан эерэг зөв хандлагыг төлөвшүүлэх сургалт явуулж байна. Мөн цалингаа хэрхэн зөв зарцуулах зэрэг эдийн засгийн боловсрол олгох сургалт явуулж, хүний хөгжлийн чиглэлээр лекц уншдаг. Ажилчдынхаа эрүүл мэндэд анхаарч архинаас гаргах эмчилгээнд хамруулахад 60 хувийн үр дүнтэй байгаа. Үүнээс гадна бид хүнийг хүндэлж, хүндлэлийг олж ажиллуулна гэдэг бодлоготой. Манай ажилтнуудын дундаж цалин 2.2 сая. Цаашид нийгмийн асуудалд анхаарч, цалин хөлсийг нь нэмэхийг зорьж байна. Манайх цэвэр нийгмийн хариуцлагын компани. Манай байгууллага дэргэдээ хүүхэд, залуус, гэр бүл, ахмадын зөвлөл ажиллуулдаг. Тухайлбал, хүүхдийн зөвлөл ажилтнуудынхаа хүүхдүүдийг олон төрлийн сургалтад хамруулахаас гадна тэдний боловсрол, мэргэжил сонголтод нь анхаарч, зөвлөгөө лекцийг зохион байгуулдаг. Мөн ёсзүйн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. "Ослыг тэглэе" гэсэн уриаг хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгч, 1990-ээд онтой харьцуулахад осол бараг тэглэгдсэн" гэж ярьж байлаа. Үүний сацуу ажлын байрыг аль болох тогтвортой хадгалж үлдэхийг эрмэлздэг байна. Цалин нь дүүргийнхээ хэмжээнд өндөрт тооцогддог, дээр нь олон жил ажиллах тусмаа цалингийн нэмэгдэл сайтай байдаг учир ажилчид нь ч тогтвор суурьшилтай ажиллахыг илүүд үздэг ажээ. Тиймдээ ч, тус компанийн 39 жилийн түүхийг хамт бичилцсэн уурхайчид ч олон байдаг юм билээ. Дээр нь "Багануур" компанийн гүйцэтгэх захирал Э.Номинчулуун ч засварчнаар компанидаа ажлынхаа гараа эхэлж, тасралтгүй 27 жил ажиллахдаа мэргэжил дээшлүүлэн инженер, албаны дарга зэрэг ажил хийж байгаад гүйцэтгэх захирлаар томилогдсон байх жишээтэй. Мөн эднийх "Нийгмийн хөгжлийн сан"-тай аж. Тус сандаа давсан орлогынхоо 0.3 хувийг төвлөрүүлэн ажилчдадаа тусладаг байна. Энэ жил гэхэд л орон сууц авсан ажилчиддаа найман сая, хашаа байшин авсан гэр бүлүүдэд дөрвөн сая, хорт хавдрын эмчилгээнд явсанд нь 10 сая төгрөгийн тусламж үзүүлж, амьдрал амьжиргааг нь дэмжжээ. Мөн инженер техникийн гурван залуу ажилтнаа мэргэжил дээшлүүлэн суралцуулахаар болж, гурван сарынх нь цалинг бүтэн олгож буй гэнэ билээ. Басхүү газар авч, тэндээ 71 айлын орон сууц барьж ажилчдаа оруулахаар төлөвлөснөөс гадна дугуйн зам, зогсоолыг байгуулан ажилчдынхаа эрүүл мэндэд анхаарч буй нь тэр бүр компаниудад байдаггүй соёл гэлтэй. Түүнчлэн "Эрүүл уурхайчин" гэсэн хөтөлбөр хэрэгжүүлж, уурхайчид нь лизингээр дугуй аваад, өглөө оройдоо дугуйгаар явдаг болсон байна. Гүйцэтгэх захирал Э.Номинчулуун ч өөрийн биеэр үлгэрлэн өглөө унадаг дугуйгаар ажилдаа ирдэг юм билээ. Энэ талаар тэрбээр "Би ч өглөө, оройдоо тогтмол дугуйгаар ирж очно. Манайхан 15 минут л жийнэ. Минийх бол дунджаар 20 минут болоод байгаа юм. Гэхдээ яах вэ. Бас давгүй шүү. Хүнд хөдөлгөөн хэрэгтэй гэдэг дээ. Хэчнээн ажиллалаа, ажиллалаа гээд хүний эрүүл мэнд шиг хэрэгтэй зүйл хаа байх вэ. Нүүрс их хэмжээгээр олборлолоо гээд ажилтан, ажиллагсад, уурхайчдынхаа эрүүл мэндийг хайхрахгүй орхиж болохгүй шүү дээ" гэлээ. Хүнээ, ажилтнаа дээдэлсэн хамт олон ямар амжилтад хүрдэгийг Багануурынхны авсан гавьяа шагнал гэрчилнэ. Тухайлбал, Багануур ХК 2005 онд бүтээмжийг амжилттай хэрэгжүүлэн "Азийн загвар компани"-аар шалгарсан бол 2011-2013 онд МҮХАҮТ-аас шалгаруулдаг "ТОП-150 аж ахуйн нэгж"-д багтаж, 2012 онд "Нүүрсний салбарын оны шилдэг олборлогч", 2013 онд Уул уурхайн салбарын "Шилдэг уурхай"-гаар шалгарч 2013 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан. 2012-2014 онд Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн газраас санаачилсан "Нүүрс" хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн. Нүүрс бутлан ачих хэсгийн хүчин чадлыг 500.0 мянган тн-оор нэмэгдүүлж, авто пүүний ачааллыг хоёр урсгалтай байхаар зохицуулж жижиглэнгийн нүүрсний борлуулалтыг гурав дахин нэмжээ. Мөн 2014-2015 онд Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар Багануурын нүүрсний ордын гүйцээх хайгуулын ажил хийгдсэн. Хайгуулын үр дүнд балансын нөөц 280.0 сая тн-оор нэмэгдэж олон улсын JORC стандартаар үнэлэгдсэн нийт 812.0 сая тн баталгаат нүүрсний нөөцтэй болсон гээд тэдний амжилтыг тоочоод баршгүй.

## Техник нь элэгдсэн ч, түлш алдаагүй хамт олон

Уул уурхайн олборлолтод машин техник хэрэгсэл хамгийн чухал үүрэгтэй. Гэвч анх байгуулагдаж байхад нь л ОХУ-аас орж ирсэн техник, тоног төхөөрөмжүүд нь одоо хүртэл ашиглагдаж байна. Зарим техникийнх нь ашиглалтын хугацаа дуусаад аль хэдийнэ 20 орчим жилийн нүүрийг үзсэн байх жишээтэй. Тиймээс техникийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлага тулгарч байгааг уурхайчид учирлаж байсан юм. Удирдлагуудын авч хэрэгжүүлж буй хүнээ дээдэлсэн бодлого, бүтээмжид суурилсан урамшуулал хийгээд ажилтнуудынх нь өөрсдийн идэвх, санаачилга, ур чадвар, чин сэтгэл л нийслэлчүүдийг гал алдуулахгүй авч явна гээд хэлчихвэл хэтийдсэн болохгүй нь.

Учир нь уурхайчид техник нь эвдэрсэн ч, засч ажиллуулсаар өнөөдрийг хүрсэн юм билээ. Уурхайн засварчид ОХУ-д 250 орчим сая төгрөгөөр зарагдаж буй шанаганы зарим материалыг худалдаж аваад 130 орчим сая төгрөгөөр дотооддоо үйлдвэрлэж чаджээ.

ЭШ 10/70 эксковаторын шанагыг Монголд анх удаа Багануур ХК-ийн Засварын хэсгийн механик Н.Хэрлэнболд, токарьчин П.Чулуун-Эрдэнэ, гагнуурчин Ц.Ариунболд, П.Эрдэнэбаатар, засварчин Р.Чулуун, П.Мөнх-Эрдэнэ нарын дархчууд үйлдвэрлэж зургадугаар сард туршилтад оруулсан байдаг. 10 шоо метрийн багтаамжтай шанага хоёр сар гаруй ашиглагдаж байгаа ч энэ хугацаанд ямар нэг эвдрэл гараагүй байна. Тэд туршилтаа гурван сар үргэлжлүүлээд, амжилттай байвал цаашид ОХУ-аас шанага авахаа болих зорилготой байгаа гэнэ. Ийм багтаамжтай, сайжруулсан буюу засварласан шанага зах зээлд 230-240 сая төгрөг байдаг бол шинэ нь 280-300 сая төгрөгийн өртөгтэй байдаг юм байна. Харин уурхайчид өөрсдийнхөө нөөц бололцоогоор эхний ээлжинд угсрахад 90-110 сая төгрөгийн зардал гарах тооцоог гаргажээ. Энэ жил "Багануур" ХК гурван шанага авах байсныхаа хоёрыг нь ОХУ-аас аваад, нэгийг нь өөрсдөө угсарсан нь энэ юм билээ. Гүйцэтгэх захирал ч "чамлахаагүй амжилт байгаа биз" хэмээн ажилчдаараа бахархан ярьж байсан юм даг. Цаашид ч тоног төхөөрөмжийнхөө материалыг аваад энэ мэтийг хийчих чадвар нөөц бий гэнэ. Гүйцэтгэх захирал Э.Номинчулуун "Ер нь бол манай ашиглаж байгаа нийт тоног төхөөрөмжийн 80 хувь нь хугацаа хэтэрчихсэн. Жишээлбэл, хөрс хуулалтын машин гэхэд 7-8 жилийн хугацаатай байдаг. Гол нь манайх өдөр, шөнөгүй ажиллуулдаг. Жолооч нь солигдохоос машин, техник нь солигддоггүй. Ээлж солигдох хоёр цагийн хугацаанд түр унтраахаас бусдаар хоногийн 22 цаг ажилладаг гэж бодохоор жил жилээр нь тооцоод үзэхээр ямар их хугацаа гарах нь ойлгомжтой. Жижиг эксковатор гэхэд 15 жил, алхагч эксковатор 20 жил ажиллах ёстой. Гэтэл манайх 37 жил ажиллуулж байх жишээтэй. Энэ нь зах зээлийн нийгэмд шилжихтэй зэрэгцээд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдээгүй гэсэн үг. Цаашид бид бүхний хувьд энэ маягаар яваад байж болохгүй. Түр зуурын засвар үйлчилгээ хийх замаар аргацаасаар байхад эргээд үйлдвэрлэлийн зардал асар өндөр болж ирж байна. Цаашид засварынхаа зардлыг даахгүй болж ирэхээр байгаа. Иймд хуучин эд ангийг сэргээх засварын төв байгуулахаар гурван тэрбум төгрөгийн төсөл бичсэн. Харамсалтай нь, толгой компаниас шууд дэмжихэд хэцүү байх шиг байна. Санхүүтэй холбоотой асуудал л даа" хэмээн ярьж байсан юм.

Үнэндээ 2012 оноос хойш л компани хэсэгчилсэн техникийн шинэчлэл хийж байсан юм билээ. Тодруулбал, 2012-2015 онд хөрс тээврийн машин дөрөв, нүүрс тээврийн машин зургаа, гинжит бульдозер нэгийг худалдан авч техникийн хэсэгчилсэн шинэчлэл

ЖЛАГА



# БАГАНУУРЫНХАН

хийж байв. Уурхайчдад зогсох эрх байхгүй. Хоногийн 24 цагийн турш тасралтгүй ажиллаж, нийслэлийг гал алдуулахгүйн тулд төлөвлөгөөнийхөө дагуу нүүрсээ нийлүүлсээр л байна.

## Өөрийн өртгөөс бага үнээр хэрэглэгчдэд нүүрсээ нийлүүлж байна

Уурхай 1995 онд хувьчлагдан төрийн өмч давамгайлсан “Багануур” хувьцаат компани болсон байдаг. Нийт хувьцааны 75 хувийг төр, 25 хувийг иргэд эзэмшдэг юм. Багануурынхан “Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацид суурилсан үндэсний тэргүүлэгч компани” болохыг эрхэм зорилгоо болгон нийгмийн хариуцлагаа цаг ямагт биелүүлсээр ирсэн. Багануурын нүүрс цахилгаан станцуудад хуваарилагдаж хотын иргэдийн дулаан, цахилгааны хэрэглээнд ашиглагддаг учир үе үеийн Засгийн газраас олборлосон нүүрсний үнийг өөрийн өртгөөс нь доогуур тогтоон хатуу бодлогоор барьж ирсэн. Хэдийгээр зах зээлийн зарчимд нийцэхгүй арга хэмжээ боловч төр өөрийн мэдлийн компаниараа дамжуулан иргэддээ үзүүлж байгаа хөнгөлөлт гэж ойлгож болох билээ. Үүнээс улбаалан, тус компани олон жилийн турш алдагдал хүлээсээр байгаа нь нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байгаагийн хамгийн тод жишээ юм. Тиймдээ ч, “Багануур” компани олон жилийн турш алдагдал хүлээж, мөн авлага өглөгийн ихээхэн сүлжээ бий болчихоод байгаа гэнэ. “Багануур”-ын нэг тонн нүүрсний өөрийн өртөг 31 мянган төгрөг. Харин ДЦС-уудад бүтээгдэхүүнээ 29500 төгрөгөөр нийлүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, нэг тонн нүүрснээс 1500 төгрөгийн алдагдал хүлээж байгаа гэсэн үг. Э.Номинчулуун даргын хэлж буйгаар Багануур ХК 6.5 тэрбум төгрөгийн авлагатай байгаа гэнэ. Тэрбээр “Өмнө нь 14-20 тэрбум төгрөг байдаг байсан. Тэр үеэ бодвол харьцангуй гайгүй. Мөн ажил авснаасаа хойш Багануурын дулааны станцид нийлүүлдэг нүүрснийхээ үнийг бууруулсан. Нийгмийн хариуцлагаа бодоод санал гаргаж, дэмжүүлсэн. Тонныг нь 14 мянган төгрөгөөр өгч байхад л 2.2 тэрбум төгрөгийн өртэй явж байна шүү дээ. Үүнийг цэгцлэхээр яриад л байна. Асуудал бас байна аа, байна. Энэ мэтээр яриад байвал олон асуудал л байна. Гэхдээ бэрхшээл тоочих бус хариуцлагаа үүрээд хамт олонтойгоо нэг сэтгэлээр ажиллах зорилготой байгаа” гэв. Мөн эд зүйлсийг үнэгүйдүүлсэн нэг асуудал бий гэнэ. Өмнө нь “Багануур”-ын техник тоног төхөөрөмж барилга байгууламж зэргийг хувьчилж авах хүсэлтэй хүмүүс хамгийн бага үнээр тогтоолгочихсон буюу үнэгүйдүүлчихсэн юм байна. Энэ нь эдийн засгийн бодит судалгаа гаргахад хүндрэлтэй болжээ. Өөрөөр хэлбэл, хэдэн тэрбумаар үнэлэгдэх ажлын байрыг л гэхэд хэдхэн сая төгрөг болгочихсон байх жишээтэй.

## Эрүүл уурхайчинтай компани

Багануурын нэгэн томоохон охин компани нь “Багануур” сувилал. “Багануур” дүүргийн төвөөс урагш 10 гаруй километрт, Хэрлэн голын эрэгт байрладаг. Уг сувилал нь уурхайн ажилчдыг ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, ажлаас хөндийрүүлэхгүйгээр сувилан эмчлэх зорилготойгоор анх 1984 онд байгуулагджээ. Уламжлалт анагаах ухааны тэргүүлэх, ахлах зэрэгтэй эмч нарын багтай энэ хамт олон эрч хүч, тамир тэнхээ сэргээх олон төрлийн өвчинг эмчилдэг байна. Тиймдээ ч, зүүн болон төвийн аймаг, Улаанбаатар хотынхон сувилуулахаар зорин очдог гэнэ. Уурхайн ажилчид амарч сувилуулахаас гадна найрсаг үйлчилгээ, чанартай эмчилгээ, гүүний саам зэрэгт татагдан холоос зорин очих нэгэн ч байдаг юм билээ. Сайн үйлчилгээтэй сувилал хэмээн 14 жил тасралтгүй сувилуулсан хүн ч байна. Мөн хэдий батлагдаагүй ч, Хэрлэн голын уснаас ууж, эргээр нь алхчихаад сахарынхаа хэмжээг үзэхэд багасчихсан байдаг шүү гэж ярих үйлчлүүлэгчтэй ч таарч явлаа.

Аймгаас мэдээлж байна

ОРХОН АЙМАГ

## Нярайн эндэгдэл гурав дахин буурчээ

Орхон аймгийн Засаг даргын нэгдсэн шуурхай хуралдааны үеэр Эрүүл мэндийн газрын дарга М.Баттүвшин нярайн эндэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гурав дахин буурсан талаар мэдээллээ.

Тодруулбал, 2016 оны наймдугаар сарын байдлаар 18 нярай эндсэн бол энэ оны мөн үед зургаан нярай энджээ. Нярайн эндэгдлийг бууруулахад нөлөөлсөн гол хүчин зүйл бол орон нутгийн зүгээс дутуу нярайд яаралтай тусламжийн үед хийдэг вакциныг шийдсэнтэй холбоотой юм. Дутуу төрсөн нярайд 15-20 минутын дотор Куросуриф, Кофениа цитрат гэдэг уушиг тэлэх зориулалт бүхий тариаг хийх ёстой байдаг ажээ. Иймд 2017 оны орон нутгийн төсвөөс 35 сая төгрөг баталж, Сурфактант эмчилгээний Куросуриф 20 ширхэг, кофениа цитрат 100 ширхэг вакцин авсан байна. Мөн Нярайн тасагт 24 цагаар ээлжээр ажиллах сувилагчийн цалинг орон нутаг шийдсэнээр дутуу нярайд яаралтай тусламж үзүүлэх мэргэжлийн баг, сувилагч ажиллах болсон юм.

Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд Нярайн тасаг ажилладаг нь бусад аймгаас давуу талтай юм. Өөрөөр хэлбэл, бусад аймагт Нярайн тасаг байдаггүй юм. Энэ нь Орхон аймгийн удирдлагууд эрүүл мэндийн салбартаа тулгамдаж буй асуудлыг цаг алдалгүй шийдэж, хөрөнгө төсөвлөж, үр ашигтай ажиллаж байгаагийн үр дүн ийнхүү гарч байна. Дашрамд дурьдахад, Орхон аймагт “Элэгний вирусгүй Эрдэнэт” аян 2016 оны есдүгээр сараас эхлэн хэрэгжиж байгаа. Энэ хүрээнд орон нутгаас элэгний вирус илрүүлэх үзлэг, шинжилгээг үнэ төлбөргүй хийж байгаа аж.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

## Төвийн болон хангайн бүсийн улсын байцаагчдын сургалт болж байна

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, “ЖАЙКА” олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран Төвийн болон Хангайн бүсийн аймгуудын Улсын байцаагчдыг чадавхжуулах зорилгоор тус байгууллагын хэрэгжүүлж буй Өрсөлдөөний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хэрэглэгчийн үндэсний хөтөлбөр зэрэг холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, дээрх хуулиудыг хэрхэн үйл ажиллагаандаа ашиглах талаарх сургалт, уулзалтыг манай аймагт зохион байгуулж байна. Сургалт хоёр өдөр үргэлжлэх бөгөөд Өмнөговь, Эрдэнэт, Дундговь зэрэг есөн аймгийн 30 гаруй улсын байцаагч удирдлагууд, Дархан-Уул аймгийн бизнес эрхлэгчид оролцож байна. Уулзалтаар өрсөлдөөний тухай хуулийн танилцуулга, холбогдох кейс, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүд болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, түгээмэл тохиолдож буй зөрчлүүдийн талаар хэлэлцэн харилцан санал солилцох ажээ. Монгол улсын зах зээл дэх өрсөлдөөний орчныг хэрхэн сайжруулах, бие биенийхээ хийж хэрэгжүүлж байгаа үлгэр жишээ ажлуудаас суралцах давуу талтай юм байна.


Food and Agriculture Organization of the United Nations

# АЖЛЫН ЗАР No:A3-GCP/MON/014/EC-A3

**АЛБАН ТУШААЛ:** Төслийн орон нутгийн зохицуулагч

**Нийтэлсэн огноо:** 2017-н оны 08-р сарын 15

**Анкет авах сүүлийн огноо:** 2017-н оны 08-р сарын 25

**ТӨСЛИЙН НЭР/КОД:** *“Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх нь (SECiM)*
*Бүрэлдэхүүн хэсэг 2: Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл GCP/MON/014/EC*

**БАЙРЛАЛ:** СЭЛЭНГЭ АЙМАГ **ГЭРЭЭТ ХУГАЦАА:12 сар (сунгах боломжтой, туршилтын хугацаатай)**

**БАЙГУУЛЛАГА:** НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага

НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага (ХХААБ) Европын Холбооны санхүүжилттэй“Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх нь: Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл”Сэлэнгэ аймагт төслийн Орон нутгийн зохицуулагч сонгон шалгаруулж авна.

НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага болон төслийн техникийн багийн удирдлагад ажиллах Орон нутгийн зохицуулагчийн гүйцэтгэх үндсэн үүрэг нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газар, хүнс хөдөө аж ахуйн газар, эрдэм шинжилгээ, хувийн хэвшлийн байгууллага болон бусад оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж, төслийг амжилттай хэрэгжүүлэх;
2. Жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хагас жил тутам явцын тайлан, сар бүр санхүүгийн тайлан гаргах;
3. Аймгийн Засаг даргын тамгын газар болон SECiM төслийн удирдлагын хэлэлцэж тохирсон асуудлыг хэрэгжүүлэх Үүнд:
   - Аймгийн нэмүү өртгийн сүлжээний маркетинг, стратегийг хөгжүүлэх,
   - Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний болон хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээний эдийн
   - засгийн загвар бий болгох, хэрэгжүүлэх (ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр)
   - Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор төслийн дэд бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нэмүү өртгийн сүлжээний платформ буюу индэр байгуулж, хамтран ажиллах, бэхжүүлэх
4. Төслийн уулзалтуудыг зохион байгуулах, зайны сургалтыг дэмжиж ажиллах, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоох, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, төлөвлөлт хэрэгжилтэд ашиглах.
5. Төслийн хүрээнд зайны сургалт зохион байгуулах, онлайн сургалт хийхэд туслалцаа үзүүлэх;
6. Аймагт ажиллах олон улсын болон үндэсний зөвлөхүүдэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах
7. Орон нутагт зарцуулагдах төсвийн зарцуулалтыг НҮБ-ын ХХААБ-ын дүрэм, журмын дагуу зохион байгуулах;
8. Төслийн хяналт, үнэлгээнд шаардагдах мэдээллийг төслийн төлөвлөгөөтэй уялдуулан цуглуулах, тайлагнах
9. НҮБ-ын ХХААБ болон төслийн багийг орон нутагт төслийн үйл ажиллагааны хэрэгжилттэй холбоотой гарч буй боломж, тулгарч буй бэрхшээлийн талаарх мэдээллээр хангах, шийдвэрлэх арга замуудыг санал болгох
10. Төсөл хэрэгжиж буй бусад аймгууд болон аймгууд дахь төслийн Орон нутгийн зохицуулагч нартай үйл ажиллагаагаа уялдуулж, хамтран ажиллах
11. Төсөл амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад үйл ажиллагааг төслийн удирдлагатай хамтарч гүйцэтгэх, санаачлан хэрэгжүүлэх

**АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- Бизнесийн удирдлага, эдийн засаг, маркетингийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Бизнес, эдийн засаг, маркетингтай холбоотой ур чадваруудыг маш сайн эзэмшсэн байх
- Хүнс, хөдөө аж ахуй, бизнесийн байгууллагад бизнес, эдийн засгийн салбарт хамгийн багадаа5 жил ажилласан туршлагатай байх
- Мэргэжлийн хувьд болон багаар ажиллах чадвартай, уян хатан байх, үүнд мэргэжлийн ёс зүй, харилцааны өндөр соёлтой, хүлээцтэй, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй, хувийн зохион байгуулалт сайтай, төлөвлөгөө боловсруулах, ажил үүргийг зөв хуваарилах, цагийг үр ашигтай ашиглаж чаддаг байх
- Англи хэлний дунд түвшний мэдлэгтэй,
- Монгол хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэг, ур чадвартай байх
- Компьютерийн хэрэглээний программуудыг (Word, Excel, Access, PowerPoint, Outlook гэх мэт) мэргэжлийн түвшинд эзэмшсэн байх

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ**

Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй хүмүүс НҮБ-ын ХХААБ-ын анкетыг (FAO Personal Profile Form (PPF)) http://www.fao.org/employment/irecruitment-access/en/сайтнаас татан авч бөглөн холбогдох тодорхойлолтуудын хамт secim-registry@fao.org хаяг руу илгээж, эх хувийг Сэлэнгэ аймгийн Засаг Даргын Тамгын Газрын (ЗДТГ) бичиг хэрэгт бүртгүүлэн хүлээлгэж өгнө үү.

Холбогдох бичиг баримтуудаа аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн бол энэ талаар secim-registry@fao.orgхаягаар давхар мэдэгдэнэ.

Хэрэв Улаанбаатар хотод байгаа бол мөн өөрийн биеэр ХХААХҮЯ-ны 9А байрны 103 тоот төслийн төв нэгжид авчирч өгнө үү.

Холбоо барих: 08:30-17:30 цагийн хооронд 70150078 дугаарын утсаар холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

Урьдчилсан сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажил горилогчдыг ажлын ярилцлагад урих болно.



**АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- Бизнесийн удирдлага, эдийн засаг, маркетингийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Бизнес, эдийн засаг, маркетингтай холбоотой ур чадваруудыг маш сайн эзэмшсэн байх
- Хүнс, хөдөө аж ахуй, бизнесийн байгууллагад бизнес, эдийн засгийн салбарт хамгийн багадаа5 жил ажилласан туршлагатай байх
- Мэргэжлийн хувьд болон багаар ажиллах чадвартай, уян хатан байх, үүнд мэргэжлийн ёс зүй, харилцааны өндөр соёлтой, хүлээцтэй, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй, хувийн зохион байгуулалт сайтай, төлөвлөгөө боловсруулах, ажил үүргийг зөв хуваарилах, цагийг үр ашигтай ашиглаж чаддаг байх
- Англи хэлний дунд түвшний мэдлэгтэй,
- Монгол хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэг, ур чадвартай байх
- Компьютерийн хэрэглээний программуудыг (Word, Excel, Access, PowerPoint, Outlook гэх мэт) мэргэжлийн түвшинд эзэмшсэн бай

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ**

Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй хүмүүс НҮБ-ын ХХААБ-ын анкетыг (FAO Personal Profile Form (PPF)) http://www.fao.org/employment/irecruitment-access/en/сайтнаас татан авч бөглөн холбогдох тодорхойлолтуудын хамт secim-registry@fao.org хаяг руу илгээж, эх хувийг Сэлэнгэ аймгийн Засаг Даргын Тамгын Газрын (ЗДТГ) бичиг хэрэгт бүртгүүлэн хүлээлгэж өгнө үү.

Холбогдох бичиг баримтуудаа аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн бол энэ талаар secim-registry@fao.orgхаягаар давхар мэдэгдэнэ.

*Хэрэв Улаанбаатар хотод байгаа бол мөн өөрийн биеэр ХХААХҮЯ-ны 9А байрны 103 тоот төслийн төв нэгжид авчирч өгнө үү.*
*Холбоо барих: 08:30-17:30 цагийн хооронд 70150078 дугаарын утсаар холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.*
*Урьдчилсан сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажил горилогчдыг ажлын ярилцлагад урих болно.*

# ЗАВСАРЛАГА

## "Ном" буланд тавтай морил

*Монголын өдөр тутмын анхдагч хэвлэлүүдийн нэг, 19 жилийн түүхтэй "Монголын мэдээ" сонины нэгэн цоо шинэ, оюунлаг, гэгээлэг булан уншигч та бүхэнд хүрч байсан билээ. Энэ бол "Ном" булан. Уншигч та бүхэн манай "Ном" буланг сонирхон уншдаг гэдэгт бид найдаж байна. "Ном" буландаа энэ удаа адал явдал, аймшиг, хүүхдэд зориулсан жанрын бүтээл туурвидаг Америкийн алдарт зохиолч Сидней Шелдоны адал явдалт зохиолын 17 дугаар боть "Их гэрийн эзэгтэй" бүтээлийг цувралаар хүргэхээр зэхлээ. Дэлхийд нэрд гарсан зохиолч, найруулагч Сидней Шелдон утга зохиолд их л хожуу буюу бүр 50 нас хүрсэн хойноо хөл тавьсан ч нэр алдраа дэлхий дахинд дуурсгаж чадсан нэгэн. Тавь гарсан "эхлэн бичигч" маань энэ үед хэдийнэ Оскарын шагналтан болчихсон байсан түүхтэй. Түүний зохиол бүтээлүүд дэлхийн улс орнуудын хэдэн арван хэл дээр орчуулагдаж, 300 сая хувиар хэвлэгджээ. Сидней Шелдоны "Хэрэв маргааш болбол", "Охин тэнгэрийн хилэгнэл", "Бурхны тээрэм", "Шөнө дундын нөгөө талд" зэрэг зохиол бүтээлүүд нь хамгийн олон хувиар хэвлэгдэж, бестселлер болж байжээ. Алдарт зохиолч Сидней Шелдон 89 насандаа таалал төгссөн билээ. Ингээд та бүхэндээ алдарт зохиолч Сидней Шелдоны "Их гэрийн эзэгтэй" бүтээлийг өргөн барья. Уншигч та бүхнийг минь номын цагаан буян ивээх болтугай.*




# ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ




## Эхлэл

**Кэйт /1982 он/**

Бүжгийн асар том танхим Кэйтийн төрсөн өдрийн баярыг тохиолдуулан ирсэн хий сүгээр дүүрэн байлаа. Тэр хий сүгүүд яс махан бие цогцостой зочдын дундуур сүлжилдэн байхыг Кэйт Блэкуэлл ажиглан, улиран өнгөрсөн өөр цаг үеэс ирсэн сүг сүнснүүд огт ажиг сэжиг аваагүй байгаа оройн гоёлын палааж, смокингтой хатагтай, эрчүүд лүгээ бүжиглэхийг харж байв. Мэн муж улсын Дарк-Харбор дахь "Хушийн гүвээ" өргөөнд хийж буй найранд зуугаад зочин хүрэлцэн иржээ. "Сүг сүнсийг эс тоолбол тэр шүү дээ" гэж Кэйт дотроо бодон инээмсэглэв. Кэйт бие гоолиг, нуруу намхан. Ихэмсэг намба төрхтэй болохоор өндөр юм шиг харагдана. Сэргэлэн бор нүдтэй, дуулгаваргүй маягийн эрүүтэй, эрс огцом тэг бүхий нүүр царай нь нэг үзсэн хүний ой ухаанд даруй харагдаж үлдэнэ. Энэ бүхэн түүнд шотланд, голланд өвөг дээдсээс нь уламжлан иржээ. Урьдын цагт мөрөн дээгүүр нь намиран унждаг асан буржгар хүрэн үс нь одоо нэгэнт бууралтсан байна. Зааны ясан өнгөтэй хилэн палаажны тодруулан сүүдэртүүлэх арьс нь аливаа настай хүнийхтэй адил тунгалаг юм шиг харагдана.

-Би 90 настай гэхэд насаа мэдрэхгүй юм. Энэ олон он жил хаашаа нисэн оддог байна вэ? хэмээн Кэйт нэг бодоод бүжиглэж буй сүг сүнснүүдийг харж,

-Эд нар л мэднэ дээ. Тэгэхэд эд нар амьд байсан. Эд нар чинь улиран одсон он жилийн нэг хэсэг, миний амьдралын нэг хэсэг... гэж бодлоо. Тэгээд баярын царайгаар мишээн буй негр эр Бандаг харав. Хажууд нь Кэйтийн хайрт Дэвид зогсож байна. Өндөр гоолиг, залуу сайхнаараа Кэйт Дэвидийг чухам ийм байх үед нь дурлаж билээ. Дэвид нааш харан инээмсэглэхэд:

-Удахгүй уулзана аа, хонгор минь удахгүй гэж бодоод жич хүүгээ үзүүлэх юмсан гэж хүсэв. Кэйт танхимыг тойруулж хараад хөвгүүнийг олж харлаа. Хөвгүүн найрал хөгжмийн дэргэд зогсоод хөгжимчдийн тоглохыг чагнаж байлаа. Тэрбээр үсээ толийтол самнаж, хар тансар хилэн пиджак, дөрвөлжин хээтэй өмд өмссөн найман настай гайхмаар хөөрхөн хүү ажээ. Роберт хүү гантигаар өнгөлсөн задгай зуухны дээр хөрөг нь өлгөөстэй байгаа хуланц эцэг Жеми Макгрегортой усны хоёр дусал шиг адилхан. Роберт хүүг өөр дээрээ харц тусаж буйг мэдэрсэн мэт эргэж харахад, Кэйт хуруугаа гозгонуулан дуудав. Зуу шахам жилийн өмнө тэнгисийн элсэн хаялганаас Кэйтийн эцгийнх нь олсон хорин кратын очир эрдэнэ болор дэнгийн гэрэлд гялалзав. Бүжиглэж байгаа хосуудын хоорондуур Роберт хөвгүүний сүлжин ойртож ирэхийг Кэйт ажиглаж байлаа. "Би улирч өнгөрсөн үеийн хүн. Энэ хүү бол ирээдүйн хүн. Миний жич хүү хэзээ нэгэн цагт "Крюгер-Брент"-ыг толгойлно доо" гэж Кэйт бодов. Хөвгүүнийг дэргэдээ ирэхэд Кэйт хажуу тийшээ болж, зай тавьж өгөв.

-Эмээ таны төрсөн өдрийн баяр танд сайхан байна уу?

-Сайхан байна. Баярлалаа, хүү минь

-Найрал хөгжим гоц сайхан юм. Удирдаач нь ёстой сонгодог зэргийнх.

Кэйт эхлээд ойлгосонгүй. Тэгснээ царай нь туяарч,

-Энэ чинь шилдэг, сайн гэсэн үг юм уу даа гэсэнд Роберт хүү инээд алдаж,

-Яг тийм. Таныг 90 настай гэхэд үнэмшмээргүй байна гэхэд Кэйт бас инээд алдаж,

-Үнэнээ хэлэхэд би өөрийгөө эмгэн болсон гэж бодохгүй байна шүү гэжээ.

Хөвгүүн эмээгийнхээ гарыг барьж, хэдийгээр 82 насны зөрөөтэй ч гэсэн хоёул хэн хэндээ ойр дотныг мэдрэн дуугүй суущгааж байлаа. Кэйт эргэж, зээ охиноо харав. Кэйтийн зээ охин, нөхөртэйгөө энэ бүжиглэж байгаа улсын дотор ямар ч яриагүй хамгийн сайхан хос нь байлаа. Робертын ээж нь хөвгүүн, эмээ хоёрынхоо хамт сууж байгааг хараад "Эмээ гайхалтай хүн юм. Өтлөхийг мартсан юм болов уу гэмээр. Хэчнээн их юм үзэж өнгөрүүлснийг нь хэн ч таамаглахгүй" гэж бодов. Хөгжим зогсож, удирдаач нь:

-Эрхэмсэг ноёд, хатагтай нар аа, энэ завшаанд залуу ноён Робертыг та бүхэнд танилцуулья гэв. Роберт хүү элэнц эмээгийнхээ гарыг атгаад төгөлдөр хуурын дэргэд очлоо. Хөгжмийн дэргэд суугаад царай нь төлөв төвшин болж, хуруу нь хөгжмийн даруулга дээгүүр гүйв. Хөвгүүн Скрябины зохиолыг тоглосон нь тэнгисийн толь мэт мандал дээр сарны туяа тусах лугаа адил байлаа. Эх нь хүүгийнхээ хөгжимдөхийг сонсоод "Үнэхээр сод авьяастай юм. Өсч том болохоороо алдартай хөгжимчин болно доо. Хүү нь эхийн гараас нэгэнт гарч, энэ дэлхийн хүн зонд хамаарах болно... " гэж бодов. Робертыг тоглож дуусахад алга нижигнэх нь сонсогдлоо. Найр өндөрлөх ойртжээ. Асар том цэцэрлэгт ширээ засаж, өнгө өнгийн дэнлүү, тууз, хийн бөмбөлгөөр чимэглэсэн байв. Хөгжимчид тавцан дээр тоглож, ширээний хоорондуур зөөгч нар үг дуугүй сүлжин зочдын таваг, хундагыг байнга сэлбэнэ. АНУ-ын ерөнхийлөгчөөс ирсэн цахилгааныг уншин сонсгов. Дээд шүүхийн дарга хундага өргөлөө. Мужийн амбан захирагч магтаалын үг хэлэв.

- ... Манай орны гайхамшигт эмэгтэйчүүдийн нэг. Өглөг буяны олон зуун байгууллагад өдий төдий их хөрөнгө мөнгө хандивласан нь үлгэр домог мэт болжээ. "Блэкуэлл сан" дэлхийн тавцанд улс орны хүн ардын эрүүл мэнд, хөгжил цэцэглэлтийн төлөө ихийг хийсэн билээ. Эрхэм Уинстон Черчиллийн хэлсэн үгийг өөрчлөсхийгээд хэлбэл "Өчнөөн олон хүнд ийм их ач тус болсон хүн өөр байхгүй". Би Кэйт Блэкуэллтэй танилцсан аз завшаандаа баярлалаа" гэв. "Үхсэн хойноо... Хэн ч намайг мэдэхгүй. Энэ хүн ямар нэгэн хутагт ахайн тухай ярьж байгаа юм шиг санагдана. Жинхэнэ Кэйт Блэкуэллийн үнэнийг мэдвэл энэ хүмүүс юу гэх бол? Ойндоо хүрээгүй байхдаа хулгайлуулж байсан, өөрөө ч хулгайч хүний хүүхэд шүү дээ, би чинь. Хэрэв өөрийн биед үлдсэн сорвийг үзүүлбэл энэ хүмүүс юу бодох бол?" гэж Кэйт бодов. Кэйт толгойгоо эргүүлж, урьд нэгэн цагт өөрийг нь алах гэж оролдсон хүнийг харав. Түүнийг нүд гүйлгэн хараад сүүдэрт зогсож буй, нүүрээ гивлүүрээр халхалсан эмэгтэй рүү харцаа шилжүүлэв. Алсад аянга нижигнэх чимээ сонсогдлоо. Мужийн амбан захирагч хэлэх үгээ дуусгаад Кэйтийг цугласан олонд танилцуулахад Кэйт бослоо. Кэйт ярьж эхлэхэд дуу нь хүчтэй болоод жигд байлаа.

-Би та нарын хэнээс ч илүү насыг наслалаа. Одоогийн залуучуудын хэлдгээр яамай байгаа даа. Гэвч би өдий насыг насалсандаа баярлаж байна. Эс тийм бол өнөөдөр дотны сайн нөхөд та нарынхаа дунд ингээд байж байхгүйсэн. Та нарын дотор миний төрсөн өдрийн баярт оролцох гэж алс холын орноос ирсэн хүн олон бийг мэднэ. Тэд нар аян замдаа ядарсан байх. Хүн болгоныг надтай адил эрчим чадалтай гэж бодох аргагүй гэхэд нь инээлдэх, алга таших сонсогдов. Кэйт үргэлжлүүлэн:

-Энэ мартагдашгүй оройг надтай хамт өнгөрүүлсэн та бүхэнд баярлалаа. Алжаасан зочид өөрсдөдөө зориулан гаргасан өрөө байранд орж амрахад болно. Бусад зочдод зориулж их танхимд бүжиг болно... гэтэл дахиад л аянга нижигнэж сонсдоход:

-Та бүхэн аадар бороонд шалба цохиулья гэхгүй бол дотогшоо орцгооно уу гэжээ.

Одоо оройн зоог нэгэнт дуусч, бүжиг тараад зочид өөр өөрсдийн тасалгаанд орцгоожээ. Кэйт сүг сүнснүүдийн дунд ганцаар үлдэв. Номын сангийн тасалгаанд улиран өнгөрсөн он жилүүдийг дурсан сууж байтал гэнэт сэтгэл нь үймрээд ирлээ."Одоо намайг Кэйт гэж дуудах хүн байхгүй болжээ. Бүгд халин одсон" гэж гуниглан бодов. Кэйтийн хорвоо давчуухан болсон шиг "Урьдын дурьтгалын навч харанхуйд эмгэнэлтэйеэ сүрчигнэнэ" гэж Лонгфелла хэлсэн бил үү дээ. Кэйт өөрөө асар удахгүй харанхуйд халин одно. Гэхдээ одоо биш "Би амьдралынхаа хамгийн гол зорилтыг биелүүлэх хэрэгтэй байна. Тэсэж байгаарай, Дэвид ээ. Би удахгүй чам дээрээ очно" хэмээн Кэйтийг бодож суутал,

-Эмээ... гэж дуудахад нь нүдээ нээв.

Халуун бүлийнхэн нь бүгдээрээ орж ирсэн байв. Кэйт тэднийгээ ээлжлэн харахдаа нэг ч жижиг сажиг зүйлийг орхигдуулсангүй. "Миний халуун бүл. Миний мөнхийн амьдрал. Алуурчин, тэнэгүүд, сэтгэл мэдрэлийн өвчтөн. Блэкуэллийнхний араг яс. Хүсэл найдлага, өвчин зовлонгийн он жилүүд... Эцсийн үр дүн нь юу байна вэ".

Зээ охин нь ойртож ирээд,

-Эмээ таны бие зүгээр үү? гэв

-Зүгээр. Би жаахан ядарчээ, хүүхдүүд минь, явж унтая гээд босож, шат руу явлаа.

Яг энэхэн мөчид аянгын дуу чих дөжрөм пижигнэж, аадар бороо асгалаа. Ширүүн борооны ус цонхыг пулемётын ээлж аятай пижигнүүлнэ. Кэйтийн гэрийнхэн бүгдээрээ шатны дээд гишгүүр дээр зогсож буй ихэмсэг бардам, намбатай, жавхлан төгс эмгэнийг нүд ширтэн харцгааж байв. Цахилгаан гялбалзаж, аянга нижигнэв. Кэйт Блэкуэлл тэднийг хараад өвөг дээдсийнхээ аялгатай үгээр,

-Өмнөд Африкт бид ийм аянга цахилгаантай аадар бороог "тандерсторм" гэдэгсэн гэв. Эрт, эдүгээ хоёр дахин хутгалдаж, Кэйт гудмаар ойр дотно сүнс сүгүүдээ дагалдуулан унтлагынхаа өрөө рүү явлаа.

**Үргэлжлэл дараагийн дугаарт...**

